



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Investing in rural people

# ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ ТӨСӨЛ

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ




2021 он

# БЭЛЧЭЭРИЙГ ХЭРХЭН ЗОХИСТОЙ АШИГЛАХ ВЭ?

Бэлчээрийн ургацын

**ТАЛЫГ НЬ АШИГЛАЖ- ТАЛЫГ НЬ ҮЛДЭЭХ НЬ**  
доройтуулахгүй байлгах үндэс болно.

НИЙ ТУРГАЦ:  
**100%**



Ургацын **50%**-ыг  
малын тэжээлд  
ашиглана.

Ургамалд төлжин  
ургах боломж  
олгож ургацын  
**50%**-ыг үлдээнэ.



Бэлчээрт үлдээж байгаа ургац (50%) нь зэрлэг амьтдын идэш тэжээл, ховор ховордсон ургамал амьтдын амьдрах орчныг хадгалах, хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах улмаар байгаль экологийн тэнцвэр, тогтвортой байдлыг хадгална. Иймээс бэлчээрийн даацыг тухайн жилийн нийт ургацын 50%-д тохируулж тооцно.

# ӨМНӨХ ҮГ



## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ДАРГА Т.ЖАМБАЛЦЭРЭН:



Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2020-2024 оны “Үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт, бичгүүдэд МУ-ын эдийн засгийн тулгуур салбарын нэгээр хөдөө аж ахуйн салбарыг тодорхойлж, олон зорилтууд тусгагдсан. Тэр дундаа мал аж ахуй, газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангах, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, импортыг орлох экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтыг гол чиглэл болгосон билээ. Дээрх зорилтуудад тусгагдсан үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, эдийн засгийг солонгоруулах, хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх,

хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байрыг бий болгож, орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг тогтвортой дээшлүүлэх, ядуурлыг бууруулахад бодит хувь нэмрээ оруулж, үр дүнтэй хамтран ажиллаж буй байгууллага бол НҮБ-ын тусгай агентлаг Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан (IFAD) юм.

Тус сангийн санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа нь 2018 оноос эхэлсэн бөгөөд бэлчээрийн зохистой удирдлага, мал аж ахуйн үйлдвэрлэл, бичил, жижиг бизнесийн хөгжил, хөдөөгийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зэрэг иргэд, малчдын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зэрэг цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж буй. Төслийн зүгээс мал аж ахуйн үйлдвэрлэл, түүний үндэс суурь болсон бэлчээрийн зохистой ашиглалтыг дэмжих чиглэлээр бодит хөрөнгө оруулалтуудыг хийж ирсэн бөгөөд 2021 оны байдлаар нийт 13 тэрбум гаруй төгрөгийг зарцуулж, 20 орчим мянган өрх төслийн үр шимийг хүртсэн тооцоо гарчээ. Үүний үр дүнд төсөл хэрэгжиж буй 6 аймагт инженерийн хийцтэй 230 худаг, мал угаалгын 140 суурин ванн, орон нутагт өвс тэжээлийн 40 агуулах саравчийг шинээр барих буюу засварлах ажлыг зохион байгуулж, малын үүлдэр угсааг сайжруулах, сайн үүлдрийн мал худалдан авах, ногоон тэжээлийн үрийг 50 хувийн хөнгөлөлттэй олгох, барьцаа хөрөнгийн дутагдалтай бичил, жижиг бизнес эрхлэгчдийг багцын батлан даалтад хамруулах шинэлэг үйл ажиллагааг тус төслөөс санаачлан эхлүүлсэн билээ. Түүний хүрээнд 4500 гаруй өрх бүхий 144 малчны бүлэг, 1800 орчим гишүүнтэй эмэгтэйчүүдийн 250 бүлэг байгуулагдсан бөгөөд гишүүдийн 60-аас багагүй хувийг чадавхжуулах сургалтад хамруулсан бол 112 малчны бүлэг бэлчээр ашиглах гэрээгээ сумын удирдлагатай байгуулж, 73 бүлгийн хил зааг, бэлчээрийн төлөвлөгөөг газар зүйн нэгдсэн системд оруулсан зэрэг томоохон үйл ажиллагаануудыг төслөөс санхүүжүүллээ. Мөн зээлийн батлан даалтын үйлчилгээг нэвтрүүлж, хоршоодод санхүүгийн дэмжлэг үзүүлсний үр дүнд малчдын байгаль, цаг уурын эрсдэлийг хохирол багатай даван туулах чадавх сайжирч, хөдөөгийн иргэдийн орлого нэмэгдэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна.

Энэ дашрамд төслийг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд оролцож, хувь нэмрээ оруулж буй Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан (IFAD), төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ажилтнууд, аймаг, сумын удирдлагууд, төслийн үр шимийг хүртэгчдэдээ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарынхаа нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлбэ.


# ТАНИЛЦУУЛГА



НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан нь хөдөөгийн иргэд тэр дундаа залуучууд, эмэгтэйчүүдийг чадавхжуулах замаар хүнсний аюулгүй байдал, эрсдэлийг даван туулах чадавхийг сайжруулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд анхааран ажилладаг ба Монгол Улс 1994 онд уг санд гишүүнээр элссэн. Дэлхийн 173 орныг эгнээндээ нэгтгэсэн тус сан 1997 оноос хойш манай улсад 44.2 сая ам долларын 3 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд 2018 оноос хэрэгжсэн “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа амжилттай үргэлжилж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй тус төсөл нь малчин өрх, сумын төвийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор дараах 6 аймгийн зорилтот 24 сумын иргэд, малчдын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Төслийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оноос бүх сумдад буюу 98 суманд хөрөнгө оруулалтын ажил хийж эхлээд байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛТОТ ХҮРЭЭ 6 АЙМГИЙН 24 СУМ



- **АРХАНГАЙ АЙМАГ:** Эрдэнэбулган, Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Хайрхан
- **ДОРНОД АЙМАГ:** Хэрлэн, Халхгол, Хөлөнбуйр, Сэргэлэн
- **ДУНДГОВЬ АЙМАГ:** Сайнцагаан, Дэлгэрцогт, Эрдэнэдалай, Сайхан-Овоо
- **ХЭНТИЙ АЙМАГ:** Хэрлэн, Батширээт, Норовлин, Өмнөдэлгэр
- **СУХБААТАР АЙМАГ:** Баруун-Урт, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Баяндэлгэр
- **ӨВӨРХАНГАЙ АЙМАГ:** Арвайхээр, Тарагт, Төгрөг, Хархорин

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа 2018 оноос эхэлснээс хойш нийт 57.274 хүн төсөлд хамрагдан үр шимийг нь хүртэж байна.

Зээл, сургалт, судалгаа, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаануудыг оролцуулахгүйгээр орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан хөрөнгө оруулалтын ажил буюу барилга байгууламжинд нийт 15 орчим төгрөгийг зарцуулсанаас 11 тэрбум төгрөгийг төслийн зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлжээ.



Малчдын нийгмийн хариуцлага, хамтын оролцооны аргад тулгуурлан бэлчээрийн зохистой ашиглах арга барилыг бий болгож, бэлчээр ашиглах эрхийг хангуулах, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхыг бэхжүүлэх зорилгоор Бэлчээр ашиглагч малчдын 144 бүлгийг байгуулав. Үүний үр дүнд 4500 гаруй өрх бэлчээрийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.



Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, тэр дундаа эмэгтэйчүүдийг чадавхжуулах ажлын байрыг бий болгох, бизнесийг нь өргөжүүлэх, батлан даалт бүхий зээлд хамруулах, зах зээлтэй холбох зорилгоор эмэгтэйчүүд давамгайлсан 1800 гишүүн бүхий 250 бүлгийг байгуулан ажиллаж байна. Бүлгийн гишүүдийн 30% нь өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй, орлого багатай иргэд байгаа юм.

“ХААН” банктэй гэрээ байгуулж, төслийн зээлийн үйл ажиллагаа эхэлсэнээс хойш 3 тэрбум төгрөгийн 256 зээл олгосноос 227 иргэнд 1.3 тэрбум, 29 аж ахуй нэгжид 1.7 тэрбум төгрөгийн батлан даалттай зээлийг олгож иргэд, аж ахуй нэгжийн бизнесийг дэмжсэн байна.



Төсөл хэрэгжсэн сумдад 26 өвс, тэжээлийн агуулах саравч шинээр барьж, 11 агуулах саравч засварласнаас гадна төслийн зорилтот сум тус бүрт 20 сая, нийт 360 сая төгрөгийг өвс, тэжээл эргэлтийн сан бүрдүүлэх зорилгоор олгосон нь малчид өвөл, хаврыг хохирол багатай даван дуулахад томоохон дэмжлэг болж байна.



Нэмэлт санхүүжилт төслийн шугамаар 2018 оноос хойш нийт 98 суманд мал угаалгын ванн, өвс тэжээлийн агуулах барьж, худаг гаргасанаас гадна 6 хүнсний ногооны зорь, мал төхөөрөх цэгийг барьж, байгуулж, 18 суманд малчдын сургалт мэдээллийн танхимыг тохижуулжээ. Сүхбаатар аймгийн эрэлт хэрэгцээг харгалзан 13 суманд мал эмнэлгийн үйлчилгээний зогсоол нийлүүлэв.



Малчдад бэлчээрээ төлөвлөн ашиглах, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, сумын төвийн иргэд, эмэгтэйчүүдэд өрхийн аж ахуйгаа амжилттай

эрхлэх, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах, хувь хүний хөгжил, хоршоод, аж ахуй нэгжүүдэд бизнес төсөл бичих, зээлд хамрагдах, туршлага, чадвар суулгах, бизнесээ тогтвортой авч явах чиглэлээр олон удаагийн сургалтуудыг орон нутагт зохион байгуулжээ. Сургалтад нийт 6808 иргэн оролцсоны 2606 эрэгтэй бол 4202 нь эмэгтэй байв.



Үлийн цагаан оготно ихтэй сумдад 122 оготно устгалын тоног төхөөрөмж олгосон нь нийт 200 мянган га талбайд устгал хийгдэж, мал бэлчих боломжтой болж, малчдын “нурууг тэнийлгэжээ”.



Бичил, жижиг бизнес эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажлын байр борлуулалтын цэгийг шинээр барих, засварлах ажлыг 24 суманд 13 ажлын байрыг шинээр барьж, 22 байрыг засварлажээ. Үүний үр дүнд 120 гаруй ажлын байр шинээр бий болж, мөн тооны иргэд ажилтай, орлоготой болоод байна.



Төслийн шугамаар байгуулагдсан бэлчээр ашиглагчдын малчдын бүлгүүдэд тус бүр 500.000 төгрөгийн дэмжлэг олгосон. Үүний хүрээнд булгийн эх, хадлангийн

талбай хаших, эвдэрсэн худаг, усг цэг засварлах, хашаа хорооны засвар зэрэг малчдад нэн шаардлагатай ажлуудыг хэрэгжүүлсэн бөгөөд түймэр их гардаг тал хээрийн бүс Дорнод, Сүхбаатар аймгийн малчид гал унтраагч багаж тоног төхөөрөмжийг өгсөн нь олон малчин айл өрх, мал, эд хөрөнгө галын аюулд өртөхөөс хамгаалж чадсан юм.



Социализмын үеэс хойш буюу 60 шахам жил орхигдсон мал угаалгын ванныг 98 сумын 140 цэгт барьж байгуулснаар өссөн дүнгээр 5 сая гаруй мал угаалгад хамрагдан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэгджээ.

Орон нутгийн оролцоотой буюу төслийн 70 хувийн санхүүжилтээр 236 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаснаар 521.9 га талбайн усан хангамж сайжирч, олон мянган хүн, мал ундаалж байна.



2020 оноос хойш “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөс 11 аж ахуй нэгжид “бар” код олгосон нь аж ахуйн нэгжүүд бараа, бүтээгдэхүүнээ сүлжээ болон дэлгүүрүүдээр борлуулах боломжтой болов.



“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлэн Говь-Алтай, Булган, Хөвсгөл, Сүхбаатар, Дорнод гэсэн 6 аймгийн хөдөө аж ахуйн 10 хоршоонд 30-126 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон нь хоршооны гишүүн 1000 гаруй хүний амьдралд дэмжлэг болно гэж үзэж байна.



“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа 2018 оноос эхэлснээс хойш нийт 57.274 хүн төсөлд хамрагдан үр шимийг нь хүртэж явна.



Хөдөө аж ахуй, мал аж ахуйтай холбоотой Засгийн газрын бодлого, шийдвэр болон олон улсын төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, мэдээлэл түгээх тогтолцоог бий болгох үүднээс мал аж ахуйн цорын ганц үндэсний, үнэ төлбөргүй лавлах “Малчин лавлах 109” мэдээллийн төвийг 2019 оноос санхүүжүүлж байна. “109” тусгай дугаар ажиллаж эхэлснээс хойш 80.000 гаруй дуудлага хүлээн авч, 3 тэрбум гаруй төгрөгийн мал хулгайд алдахаас урьдчилан сэргийлж ажиллажээ.

**С.ЗАНДАНБАЛ:**

# ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН АМЬДРАЛ, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ТОМООХОН АХИЦ, ДЭВШИЛ ГАРЧ БАЙНА



Хөдөө орон нутаг тэр дундаа мал аж ахуйн салбарт хамгийн хүртээмжтэй, зорилтот хүмүүстээ хүрч чадсан, бодит үр дүнгээ өгсөн төсөл бол “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл юм. Тус төслийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд, цар хүрээ, үр дүн, ач холбогдол, өгөөжийн талаар төслийн зохицуулагч С.Занданбалтай ярилцлаа.



хэрэгждэг бөгөөд бүгд өөр, өөрийн онцлогтой, зорилго зорилт, хүрэх үр дүнгээ тодорхойлсон байдаг. Манай төслийн хувьд иргэд, орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан төлөвлөлтийг хийж, аль болох иргэд, малчдад тулгамдаж байгаа асуудлыг цогцоор нь шийдвэрлэхийг чармайн ажиллаж байна. Монгол улсын Засгийн газар, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сантай байгуулсан төслийн санхүүжилтийн хэлэлцээрт зээлийн хөрөнгийг хэрхэн зарцуулахыг нарийн заасан байдаг. Тухайлбал ажил буюу барилга байгууламжид нийт зээлийн 36%, зээл, зээлийн батлан даалтад 11%, сургалт болон үйл ажиллагааны зардалд тус бүр 10% гэх мэт тусгадаг. Бид зээлийн хэлэлцээрээ баримтлан ажиллаж байгаа хэдий ч иргэд, орон нутгийн эрэлт хэрэгцээ, төслийн хэрэгжүүлэгч болох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бодлого, үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөлт, гүйцэтгэлийг хэрэгжүүлэхэд бодит хөрөнгө оруулалтын ажилд нийт зээлийн хөрөнгийн 50 гаруй хувийг зарцуулахаар байна. Иргэдийн хувьд нүдэнд харагдаж, гарт баригдах хөрөнгө оруулалтыг бодитой дэмжлэг гэж үздэг. Тийм ч учраас төслийн хөрөнгө оруулалтын ажлуудыг орон нутагт талархан хүлээж авдагийн дээр иргэд, малчдынхаа эрэлт хэрэгцээнд үндэслэн хийдэг учраас бодит үр дүн шууд гардаг. Өвөрхангай аймагт гэхэд мал аж ахуйн салбарт сүүлийн

**- Монгол Улсад хэрэгжиж буй үр дүнтэй томоохон төслүүдийн нэг бол “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл. Төслийн талаар товчхон танилцуулахгүй юу?**

НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийг 2012-2017 онд хэрэгжүүлсэн. Санхүүжүүлэгч байгууллагаас төслийг үр дүнтэй хэрэгжсэн гэж үзэж 2017 онд Нэмэлт санхүүжилтийг баталснаар 2018 оны 6 сараас Архангай, Дорнод, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай гэсэн 6 аймагт хэрэгжиж байна. Төслийн гол зорилго нь хөдөөгийн иргэд, малчид, бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний орлогыг нэмэгдүүлэх явдал юм. “Зах зээлийн хөгжил”, “Бэлчээрийн менежмент ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” гэсэн 2 үндсэн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд, иргэдийн сайн дурын байгууллага болох малчны болон эмэгтэйчүүдийн бүлгүүдийг байгуулж чадавхжуулах, цаг уурын хүндрэлийг эрсдэл багатай даван туулах болон мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бичил, жижиг бизнесийг дэмжих чиглэлээр хөрөнгө оруулалтуудыг хийх, бэлчээрээ хамтран төлөвлөж, ашиглах болон өрхийн болон жижиг бизнес эрхлэх, бүтээгдэхүүний технологийн

сургалтуудыг зохион байгуулах, барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэдэд баглан даалттай, хүү багатай зээлийг олгох, ажлын байраар хангах, зах зээлээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлдэг.

**-Төсөл хэрэгжиж буй сумдын иргэд их ам сайтай байна лээ. ЗЗБУХТ нь бусад төслүүдээс юугаараа онцлог давуу талтай байна вэ?**

Манай улсын хөгжлийн нэг гол тулгуур болохын хувьд хөдөө аж ахуйн салбарт багагүй төсөл, хөтөлбөрүүд



10 жилд хийгдээгүй хөрөнгө оруулалт хийгдсэн гэдгийг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын газраас үнэлж байсныг дурдахад илүүдэхгүй болов уу. Төслийн бас нэг онцлог нь хөрөнгө оруулалтын ажилд орон нутгаас доод тал нь 30 хувийн санхүүжилтийг хийдэг. Энэ нь оролцоо, хариуцлага, тогтвортой байдал, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл хүн өөрөөсөө хөрөнгө, мөнгө гаргасан учраас түүнийхээ үр шимийг харах, арчилж, хамгаалж, хариуцлагатай байж, эзний сэтгэлээр ханддаг. Бид хөрөнгө оруулалтын ажил бүр дээр холбогдох талуудтай ашиглалтын гэрээ байгуулж, цаашдын тогтвортой байдлыг хангахад анхаарч ажиллаж байна. Хөдөөгийн иргэдийн хувьд чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа буюу сургалт, зөвлөгөө хөрөнгө оруулалтаас дутахааргүй чухал байдаг ч ач холбогдолыг нь дутуу үнэлэх явдал аль ч түвшиндээ байгаа нь ажиглагддаг. Нөгөө талаар сургалт, мэдээллийн үр дүн тэр дороо гардаггүй. Мэдлэг, мэдээллийг өөрийн болгож амьдралд үр өгөөжийг нь харах, ялангуяа иргэдийн ойлголт хандлагыг өөрчлөхөд багагүй хугацаа хэрэгтэй. Хөрөнгө оруулалтын бодит дэмжлэгүүдээс гадна иргэдийг мэдлэг, мэдээллээр хангах ажлыг бид мэргэшсэн төрийн бус байгууллага болох мэргэжлийн холбоодоор дамжуулан хийдэг. Тухайлбал бэлчээр ашиглалтын малчдын бүлэг байгуулах сургалт, семинар зохион байгуулах ажлыг “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо”, Эмэгтэйчүүд давамгайлсан бүлэг байгуулж, зах зээлтэй холбох, бичил зээлд хамруулах үйл ажиллагааг “Монголын үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын холбоо”, Хөдөө аж ахуйн хоршоодыг чадваржуулах, бизнесийг нь хөгжүүлэх, төсөл бичих сургалтуудыг “Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо” хэрэгжүүлж байна. Мэргэжлийн туршлагатай ТББ-уудыг сонгосноор иргэд, малчдынхаа цаг үеийн байдалтай уялдуулж, яг хэрэгтэй, тулгамдсан асуудлаар сургалт зөвлөгөө өгдөг. Энэ нь манай төсөл үр дүнтэй хэрэгжих бас нэг давуу тал болдог гэж бодож байна. Түүнээс гадна манай төслийн нэг үр дүнтэй ажил бол бага хувийн хүүтэй, батлан даалттай зээл олголт. Жилийн 10.8 хувийн хүүтэй, дээр нь барьцаа хөрөнгө дутагдалтай иргэн, аж ахуйн нэгжид төслөөс батлан даалтын үйлчилгээ үзүүлж байгаа. Зээл авах гэхээр манайханд тулгардаг гол асуудал бол барьцаа хөрөнгө байдаг шүү дээ. Энэ тал дээр дэмжлэг үзүүлэхээр “ХААН” банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан.

#### **-Төслийн зээлд хэрхэн хамрагдах вэ?**

Төслийн аймаг буюу дээр дурдсан 6 аймгаас гадна төслийн эхний шат хэрэгжсэн Хөвсгөл, Булган, Говь-Алтай аймгийн бичил жижиг бизнес эрхлэгч хэн ч бай төслийн зээлд хамрагдах эрхтэй. Өөрийн сумын “ХААН” банкны салбарт хандаад Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн зээл авъя гээд банкны холбогдох

шалгуурын дагуу зээлээ судлуулж болно. Зээлийн эх үүсвэрийг банк өөрөө гаргана.

#### **-Малчдын аж амьдралын амин сүнс болсон бэлчээр, худаг ус, малын эрүүл мэндийн чиглэлээр төслийн шугамаар олон үр дүнтэй ажлууд хийгдэж байгаа юм билээ...**

Бэлчээрийн мал аж ахуй зонхилон эрхэлдэг манай улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгаль цаг уурын бэрхшээлийг эрсдэл багатай даван туулах чадавхийг бэхжүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Ингэхийн тулд мэдлэг, мэдээлэл, бодит хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэр гээд бүх талын л дэмжлэг хэрэгцээтэй болно. Ер нь судалгаанаас харахад хөдөөгийн иргэдийн хувьд хамгийн хэрэгцээтэй дэмжлэгт худаг ус, хүү багатай зээл буюу санхүүгийн эх үүсвэр ордог. Тийм учраас тэдний хэрэгцээнд нийцүүлэн гүн өрмийн худаг 230 гаруйг (2021 оны дүнг оруулаад) гаргасан. Худаг уснаас гадна малчдад нэн чухал шаардлагатай мал угаалгын ванн, өвс, тэжээлийн агуулах шинээр барих асуудлуудыг шийдэж өгсөнөөр малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн, малын ашиг шимийг нэмэгдүүлэхэд томоохон хөрөнгө оруулалт болсон. Төслийн хүрээнд 37 суманд өвс, тэжээлийн нөөцийн агуулах, саравч шинээр барьж, засварлах, 140 бог малын угаалгын ванн барьж, сум бүрт малчдад зориулсан мэдээллийн төвийг тохижуулж, 122 ширхэг үлийн цагаан оготно устгах иж бүрдэл төхөөрөмжийг нийлүүлж, 18 суманд эрсдэлийн сан бүрдүүлэхэд зориулж 360 сая төгрөгийг санхүүжилтийг олгох зэрэг ажлууд хийгдээд байна. Төслийн зорилтот сумдад малчдын бүлгүүдийг байгуулж, бэхжүүлэх, хоршоо болгон хөгжүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах чиглэлээр малчдад үе шаттай сургалтыг зохион байгуулсны үр дүнд малчид маань бэлчээрээ төлөвлөгөөтэй, хуваарьтай ашиглаж, хамгаалж, хөдөлмөрөөрөө хоршиж, хамтран ажиллаж сурч байна.

#### **-ЗЗБУХТ-ийг хэрэгжүүлснээр гарсан томоохон үр дүнгүүдээс хуваалцвал...**

Төсөл хэрэгжсэнээр бэлчээрийн менежмент сайжрах нөхцөл бүрдсэн гэж үзэж байна. Малчид маань бүлгийн зохион байгуулалтаар ажилласнаар хамгийн их тулгамдаж буй бэлчээрийн доройтлын асуудлыг хамтран хэлэлцэж, хуваарьтай ашиглах, цаашлаад өрхийн амьжиргаагаа дээшлүүлэхэд нэмэр болох нь дамжиггүй. Усны хомсдолоос болж ашиглаж чадахгүй байгаа бэлчээрт худаг гаргаснаар бэлчээрийг хуваарьтай ашиглахад дөхөм болохоос гадна нэг үе орхигдоод байсан мал угаалгын вангын барьж өгснөөр малын паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдсэн. Тухайлбал төсөл хэрэгжиж буй 6 аймгийн хэмжээнд 2021 оны дүнг оруулаад 230 инженерийн хийцтэй худгийг гаргаснаар 2500 орчим малчин өрхийн 2 сая гаруй толгой мал усаар хангагдаж бэлчээрийн усан хангамж дунджаар 3-5 хувиар нэмэгдсэн, 140 бог мал угаалгын

суурин ванн барьсанаар 20 орчим мянган өрхийн давхардсан тоогоор 5 сая гаруй толгой малыг угаалгад хамруулж паразит өвчнөөс урьдчилан сэргийлэхэд томоохон хувь нэмэр болсон. Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор 37 орчим сумдад өвс, тэжээлийн агуулах, саравчийг шинээр барих буюу засварласнаар өвлийг эрсдэл багатай даван туулахад ихээхэн дэм болсон зэрэг нааштай үр дүн олныг дурдаж болно. Мөн өвс, тэжээлийн нөөц бэлтгэх шаардлагатай 18 суманд тус бүр 20 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэнээр цаашид эрсдэлийн эргэлтийн сан бүрдүүлэхэд том дэмжлэг болсныг орон нутгийн удирдлага хэлж байсан. Түүнчлэн орон нутагт ажлын байр болон борлуулалтын цэг буюу манайхны хэлж заншсанаар худалдааны төвийг барьсанаар бичил, жижиг бизнес эрхлэгчдийн хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, шинээр ажлын байр бий болж, өрхийн орлого нэмэгдэх боломж бүрдэж байна. Мөн төслийн зорилтот 18 суманд бэлчээр, байгалийн нөөц, эдийн засаг гээд бүх асуудлыг тусгасан сумын “Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө” боловсруулж өгсөн нь сумын удирдагч орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийг хийх суурь болох чухал баримт бичиг боллоо. Төслийн санхүүжилтээр Түгэмэл хэрэгцээтэй хүнсний ногоо, жимс хадгалах, тээвэрлэх болон бөөрөнхий байцаа савлах, тээвэрлэх 2 стандартыг боловсруулж батлуулсан нь хүнсний аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах чухал алхам болсон. Одоо бог мал угаалгын ванны стандартыг боловсруулахаар Мал эмнэлгийн ерөнхий газартай хамтран ажиллаж байна.

#### **-Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан төслийн хэрэгжилтийн явц удааширч, 2023 он хүртэл сунгагдаж байгаа юм байна. Үлдсэн хугацаанд ямар ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа вэ?**

Цар тахлын улмаас олныг хамарсан үйл ажиллагаа явуулах боломжгүй болсонтой холбоотойгоор сургалт, чадавх бэхжүүлэх ажлууд маань нэлээн хоцрогдолтой явж байгаа. Хөрөнгө оруулалт зэрэг бусад ажлын хувьд төлөвлөсний дагуу хэрэгжиж байгаа гэж хэлж болно. Түүнчлэн Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоотой хамтран тэдний гишүүн хоршоодод хөнгөлттэй зээл олгохоор гэрээ байгуулсаны дагуу хоршоодод зээл олгох ажил одоо хийгдэж байна. Мөн ХХААХҮЯ-наас санаачилсан малынхаа тоонд бус чанарт анхаарах аяны хүрээнд ОХУ-ын гурван мужаас өндөр ашиг шимтэй малыг оруулж ирсэн нь Монголын малын чанар, ашиг шимийг сайжруулахад томоохон суурь болно гэж харж байгаа. Мэдээж батлан даалттай зээл олголтоо үргэлжлүүлэх, орон нутагт нэн шаардлагатай байгаа ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

*Ярилцсан: С.Мөнхжаргал*



Монголын үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын холбооны Ерөнхийлөгч С.ЭНХТУЯА:

## ОРОН НУТГИЙН ОЛОН ӨРХ ТОЛГОЙЛСОН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД ТӨСЛИЙН БУЯНААР АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ БОЛСОН

МҮҮХХ нь 1990 онд байгуулагдсан, 21 аймагт салбартай, 80 гаруй бичил, жижиг бизнес эрхлэгчдийг эгнээндээ нэгтгэсэн, хоршооллын сургалт мэдээллийн төвийн үүсгэн байгуулагч холбоодын нэг.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлага” төсөлтэй бид 2012 оноос хойш хамтран ажилласан бөгөөд Нэмэлт санхүүжилт буюу 2018 оноос хэрэгжиж байгаа энэ үе шатны хүрээнд 6 аймгийн 24 суманд 1800 гаруй гишүүнтэй, 250 эмэгтэйчүүд давамгайлсан бүлгийг байгуулсан. Манай холбооноос бүлгийн гишүүдийг хөгжүүлэх, тогтвортой байлгах, өрхийн үйлдвэрлэл амжилттай эрхлэх, бизнес төсөл бичих, технологийн, хоршооны, аймгуудын бүсчилсэн туршлага судлах уулзалт зэрэг сургалтуудыг зохион байгуулдаг. Анхны уулзалтаар ихэнх гишүүд өөрийгөө илэрхийлэх чадваргүй, асуултад хариулж чадахгүй, их бүрэг ичимтгий байсан. Харин үе шаттай олон удаагийн сургалт явуулж, уулзалт семинарт хамруулсаны үр дүнд хүмүүс минь их сайн хөгжиж, өөрийн байр суурь, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж сурснаас гадна нийгмийн идэвх нь эрс нэмэгдсэн. Мөн сургалтад хамрагдсан хүмүүсийн өрхийн үйлдвэрлэл нь өргөжиж, ашиг орлого нь нэмэгдэж, ажилгүй



байсан олон хүмүүс ажлын байртай болж, зээлд хамрагдан олон бүсгүйчүүд эрх мэдэлтэй, хувь хүний хувьд өөрийн гэсэн байр суурьтай, хамт олонтой болж хөгжин дэвшээд байна. Төслийн шугамаар байгуулагдсан бүлгүүд маань ч өргөжиж хоршоо болон ажиллаж буй олон сайхан жишээ байна.

ЗЗБУХТ-өөс сургалтын бүх зардлыг дааж, бүлгийн гишүүдийг хэд, хэдэн удаа гадаадад туршлага судлах арга хэмжээнд хамруулсан. Мөн аймаг, сумын төвүүдэд ашиглагдахгүй байгаа байрыг засварлаж бүлгийн гишүүд үйлдвэрлэлээ явуулж, ажлын байр, сургалт, мэдээллийн танхим бэлдэж өгөх, бараа бүтээгдэхүүнээ борлуулах борлуулалтын цэг шинээр барьсан зэрэг нь маш том дэмжлэг болсон. Энэ нь орон нутгийн

иргэдэд ч, сургалт явуулж байгаа бидэнд ч тохь тухтай сайхан байдаг.

Дараагийн чухал зүйл нь үйлдвэрлэл буй бараа бүтээгдэхүүнд нь “бар” код олгосон. Мөн бүлгийн гишүүн бүр зээл авах боломжтой болсон нь олон үйлдвэрлэл эрхлэгчдэд томоохон дэмжлэг болж байна. Анх бүлгээрээ зээл авч гишүүддээ хуваахаар төлөвлөгдсөн байсан нь хэрэгжилтийн явцад өөрчлөгдөж хүртээмж нь нэмэгдсэн юм. Эхлээд бид төслийн зорилгод бүлгийн орлого багатай, өрх толгойлсон, эмэгтэйчүүдэд анхаарал хандуулдаг байсан бол өрх толгойлсон эрэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд анхаарах хэрэгтэй гэдэг нь ажиглагдаж байна.

Ер нь төслөөс хийе, бүтээе гэсэн бүхий л хүмүүсийг дэмжиж, үйл ажиллагааг нь зохион байгуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлж ирсэн гэхэд хэтрүүлсэн болохгүй болов уу. Үнэхээр л хөдөлмөрлөж чаддаг хүнд бол өөрсдийнх нь санал хүсэлт, тулгарч буй асуудал, хэрэгтэй зүйлсийг нь төслөөс шийдэж өгч, хөдөлмөрлөн хөгжиж, сайн сайхан амьдрах боломжоор бүрэн хангаж байгаад олон иргэд баяртай байгаа. Орон нутгийн олон өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэд төслийн буянаар ажилтай, орлоготой болсон доо.



Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны Гүйцэтгэх захирал Н.ГАНХУЯГ:

## ТӨСЛИЙН ҮР ДҮНД МАЛЧИД ЦААШИД МАЛ АЖ АХУЙГАА АМЖИЛТТАЙ ТӨЛӨВЛӨН, БАЙГАЛИЙН ГАМШГИЙГ ГАРЗ, ХОХИРОЛ БАГАТАЙ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРТАЙ БОЛСОН

Манай холбоо “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээний 6 аймгийн 18 суманд бэлчээрийн менежментийн ажлыг хариуцан ажиллаж байгаа. Бэлчээрийн менежментийн хүрээнд олон ажил хийгддэг. Бид малчдыг бүлгийн зохион байгуулалтад оруулж, бэлчээрийн менежмент, малын чанар, малчдын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулж ирсэн. Төслийн нэмэлт санхүүжилт хэрэгжиж эхэлснээс хойш Бэлчээр ашиглагч малчдын 141 бүлгийг байгуулсны үр дүнд 4100 гаруй өрх бэлчээрийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна. Бүлгүүд хамтран ярилцаж, дөрвөн улирлын бэлчээрийн бүс нутгуудаа тодорхойлоод, тэнд хэчнээн тооны мал, ямар хугацаагаар байх вэ гэдгээ тооцоолон төлөвлөгөө гаргахад нь бид мэргэжлийн зөвлөгөө өгч, тусалж дэмжиж байгаа. Үүний үр дүнд одоо малчид нүүдэл суудлаа ямар цаг хугацаанд хэрхэн зүй зохистой хийх вэ гэдгээ ярилцаж бэлчээрийн даац хэтэрсэн бүс нутгуудаа аль болох богино хугацаанд цөөн мал байлгах, даац хэтэрсэн



тохиолдолд нэмэгдэл тэжээлийн хэрэгцээг тооцож, түүнийгээ хаанаас бэлтгэх зэрэг олон асуудлаа шийдвэрлэдэг болсон байна.

Малчид хамтаараа ярилцаж гаргасан төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд нь орон нутгаас нь ямар дэмжлэг үзүүлэх, төслөөс, малчдаас ямар зардал гаргах вэ гэдгээ гурван жилийн төлөвлөгөөндөө тусгаад багийн ИНХ болон сумын ИТХ-аар хэлэлцэж батлуулдаг болсон нь төсөл хэрэгжсэний хамгийн гол үр дүн юм. Мөн малчид төслийн шугамаар Монгол улсад анх удаа бэлчээрийн гуравласан гэрээ байгуулж, бэлчээрийн зураг гаргаж, газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлсэн. Энэ нь цаашдаа малчид бэлчээрээ төлөвлөн он удаан

жил ашиглахад эерэг үр өгөөжтэй ажил болсон. Мөн төслийн зүгээс малчдад нэн шаардлагатай, тулгамдсан асуудлуудыг шийдэж өгсөн. Тухайлбал бүлгүүдэд жилд нэг удаа 500.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж, мал угаалгын ванн болон өвс, тэжээлийн агуулах савыг барьж, худга ус шинээр гаргах, засварлах, булаг, бэлчээр хаших, хашаа хороо засварлах, оготно устгах болон түймэр унтраах багаж, төхөөрөмжүүдийг өгч, малчдад тулгамдсан, амин чухал асуудлуудыг шийдэж өгсөн. Төсөл хэрэгжсэний бас нэг том үр дүн нь малчид дундын мөнгөн хуримтлалын сантай болсон явдал. Малчид болон төслийн зүгээс ижил хэмжээний мөнгө хийж сангаа бүрдүүлж, үүнийгээ олон төрлөөр зарцуулах, байгалийн гамшгийн үед ашиглах боломжтой. ХХААХҮЯ, төслөөс ган, зудыг хохирол багатай даван туулахад бүхий л талаар дэмжиж, тусалсанд олон малчид баяртай байгаа. Төсөл хэрэгжээд дууссаны дараа ч малчид бүлгийн зохион байгуулалтаараа мал аж ахуйгаа амжилттай төлөвлөн авч явж, бэлчээрийнхээ менежментийг он удаан жил зөв зүйтэй хийж, байгалийн гамшгийг гарз, хохирол багатай даван туулах чадвартай болсон.





Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны дэд Ерөнхийлөгч Ц.АЛТАНТУЯА:

## ЗЗБУХТ НЬ ОРОН НУТГИЙН ИРГЭД, МАЛЧИД, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛД ТОМООХОН СУУРЬ БОЛЖ БАЙНА

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл анх Монголд хэрэгжсэн цагаас л манай холбоо хамтарч ажиллаж байгаа. Манай холбоо төслийн зах зээлийн бүрэлдэхүүн хэсэгт нь хамтарч ажиллаж, малчдын бүлгүүдийг хоршоо болгох, гишүүдэд чиглэсэн үйлчилгээг нь нэмэгдүүлэх, ашиг орлогоо өсгөн өргөжин тэлэх, мөн зах зээлд чиглэсэн өртгийн сүлжээнд тоглогч нь болж оролцох боломжоор хангаж байгаа. Бид эхний ээлжид хоршоо байгуулах сургалтуудыг хийж, хоршоо болсны дараа нь бизнесийн үйл ажиллагааг нь хөгжүүлэх шат дараалсан сургалтуудыг зохион байгуулдаг.

Нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд хөдөө аж ахуйн хоршоодыг зорилтот аймгуудад хөгжүүлэх чиглэлээр хамтарч ажиллаж байна. Ялангуяа бизнесийг нь хөгжүүлэх, тогтвортой

удаан хугацаанд амжилттай авч явах чадвар суулгах, бизнес төсөл бичих сургалтуудыг зохион байгуулдаг. Сургалтуудынхаа үр дүнд хоршоодынхоо бизнес санаануудыг нь эрэмбэлээд хамгийн их хэрэгжих боломжтой, үр ашиг гарахуйц төслүүдийг сонгож, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл рүү илгээж, хөнгөлөлттэй зээлд хамруулж байгаа. Энэ жилийн хувьд нийт 16 хоршооны бизнес санаа шалгарснаас 11 хоршоо нь зээл авах эрхтэй болж, Говь-Алтай, Булган, Хөвсгөл, Сүхбаатар, Дорнод зэрэг зургаан аймгийн 9 хоршоодод 30-126 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-өөс олгоод байна. Тус дэмжлэгийг олгосноор хөдөө аж ахуй тэр дундаа мал аж ахуйн үйлдвэрлэл, малын гаралтай түүхий эдийн боловсруулалт,

борлуулалт сайжирч, хоршооны гишүүн 1000 гаруй хүний амьдралд томоохон дэмжлэг, тус болж байгаа. Хоршоод маань гишүүдийнхээ орлогыг нэмэгдүүлэх, орон нутагт нь тулгамдаж буй асуудлыг өөрийнхөө бизнес төлөвлөгөөгөөр дамжуулан шийдвэрлэх олон оновчтой, үр дүнтэй санаануудыг дэвшүүлсэн байсан. Өмнө нь хоршоод зээл авах боломжгүй, харин жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан зээлд хамрагдаж байсан бол одоо зөвхөн хоршоодод зориулсан зээлд хамрагдах боломжтой болж буй нь ирээдүйд хоршоод хөгжих, үүнийгээ дагаад сум, орон нутгийн иргэд, ялангуяа малчдын амьдрал ахуй сайжрах, хөдөөгийн хөгжилд томоохон суурь болж өгч байна. Энэ бол “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” /Нэмэлт санхүүжилт/ төсөл хэрэгжсэний үр дүн юм.



Төслийн Зээлийн батлан даалтын сангийн менежер М.БАЯРМАА:

## ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ АЙМАГ, СУМАНД ӨРХИЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧ АЛЬ Ч ИРГЭН, ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧ ХОРШООД, ААН-ҮҮД БАТЛАН ДААЛТТАЙ ЗЭЭЛД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ

ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн гол онцлог нь Монголд анх удаа багцын батлан даалт буюу хөдөөгийн орлого багатай иргэдэд санхүүгийн цоо шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлсэн явдал юм. Багцын батлан даалт гэдэг нь бичил зээл авах шаардлага тулгараад банкны шаардлагыг хангасан хэдий ч барьцаа хөрөнгийн дутагдалтай байгаа тохиолдолд тус төслөөс батлан даалтыг банкаар дамжуулан автоматаар гаргах ба ингэхдээ ямар нэгэн бичиг баримт нэмж бүрдүүлэх, батлан даагчийн шийдвэр хүлээх шаардлагагүй, шуурхай, чирэгдэлгүйгээрээ давуу талтай. Зорилтот бүлгийн 9 аймгийн 156 сумын иргэдэд 20 сая хүртэлх төгрөгийн 10,8 хувийн хүүтэй, 36 сар хүртэлх хугацаатай, зээлийн дүнгийн 80% хүртэлх батлан даалт, эргэлтийн хөрөнгийн зориулалтаар авч буй 10 сая хүртэлх төгрөгийн, 24 сарын хугацаатай зээлд мөн л 80% хүртэлх батлан даалтыг Хаан банктай хамтран гаргаж байна. Хөдөө аж ахуйн бизнесийн үйл ажиллагаа явуулдаг хоршоо, аж ахуй нэгжид 75 сая хүртэлх зээлийг, компанид 50% хүртэлх, хоршоонд 60% хүртэлх батлан даалттай олгох боломжтой. Өөрөөр хэлбэл, төсөл хэрэгжиж буй аймаг, сумын өрхийн түвшний үйл ажиллагаа явуулж буй хэн ч байсан өөрт ойр Хаан банкны салбар дээр очоод “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын зээл”-д хамрагдах боломжтой.

Зээл хүсэгчдэд нэг зүйлийг анхааруулж хэлэхэд ялангуяа хөдөө аж ахуйн чиглэлийн бизнес эрхлэгчид орлогоо нотлох тал дээр учир дутагдалтай байна. Жишээ нь сүүгээ зараад 10,000 төгрөгийн орлого ороход дансаар шилжүүлж авахдаа гүйлгээний утга дээр нь ямар орлого вэ гэдгээ тодорхой бичээгүйгээс болоод нотолж чаддаггүй. Мөн төслөө өөрийн болгож сайн боловсруулаагүйгээс болж олон дахин буцаагддаг. Зах зээлийн судалгаагаа бас бодитой сайн хийх хэрэгтэй. Анх удаа зээл хүсч байгаа хүмүүс банканд дээр их бүдэрдэг. Банкны зүгээс хөдөө аж ахуйн бизнесийг эрсдэл өндөртэй гэж хардаг тул тухайн зээл хүсэгч давхар бизнес эрхэлдэг бол давуу талтай байдаг. Тухайлбал, зах дээр

барааны лангуу ажиллуулдаг хүн цагаан идээ боловсруулах гэсэн юм гээд хүсэлтээ өгвөл банк хэрвээ энэ төсөл нь бүтэлгүйтвэл зах дээр байгаа лангуу нь зээлийнх нь эрсдэлийг хаана гэж тооцоолоод зээл олгодог. Энэ төсөл хэрэгжээд дууссаны дараа хөдөөгийн иргэд, ХАА-н бизнес эрхлэгчдийг дэмжих зориулалттай батлан даалтын зээлийн үйл ажиллагааг цаашид ХХААХҮЯ-наас урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлнэ. Та зээлийн хүсэлтээ гаргаад банкны шаардлагыг давсан л бол манай төслөөс батлан даалтыг ямар нэгэн чирэгдэлгүйгээр шуурхай гаргаж өгнө. Төсөл хэрхэн бичих талаар зөвлөгөө авахыг хүсвэл манай төслийн аймгийн идэвхжүүлэгч нарт хандаж болно.

№	Аймаг	Нэр	Албан тушаал	Утас	И-мэйл хаяг
1	Улаанбаатар /төв төсөл/	М.Баярмаа	Зээл, батлан даалт харуусан менежер	99115431, 77117466	<a href="mailto:Bayarmaa@pmpmd.mn">Bayarmaa@pmpmd.mn</a>
2		З.Лхагвадорж	Зээл, батлан даалт харуусан мэргэжилтэн	99117733, 77117466	<a href="mailto:Lkhagvadorj@pmpmd.mn">Lkhagvadorj@pmpmd.mn</a>
3		Э.Дэлгэрсайхан	Зах зээлийн хөгжил харуусан мэргэжилтэн	99070665, 77115040	<a href="mailto:Delgersaikhan@pmpmd.mn">Delgersaikhan@pmpmd.mn</a>
4		С.Гүн-Уянга	Төслийн дэд зохицуулагч	99270502, 77115040	<a href="mailto:gun-uyanga@pmpmd.mn">gun-uyanga@pmpmd.mn</a>
5	Архангай	Г.Лхагвасүрэн	Аймгийн зохицуулагч	99033051, 88280344	<a href="mailto:Gochoolhagwasuren@gmail.com">Gochoolhagwasuren@gmail.com</a>
6	Булган	Д.Дарьсүрэн	Аймгийн зохицуулагч	99349400	<a href="mailto:Darisuren.uran@gmail.com">Darisuren.uran@gmail.com</a>
7	Говь-Алтай	С.Эрдэнэчимэг	Аймгийн зохицуулагч	99488859	<a href="mailto:dashdavaadulmaa@gmail.com">dashdavaadulmaa@gmail.com</a>
8	Дорнод	О.Одончимэг	Аймгийн зохицуулагч	88030899, 88287765	<a href="mailto:Phoneuser5511@gmail.com">Phoneuser5511@gmail.com</a>
9	Дундговь	Ө.Дугармаа	Аймгийн зохицуулагч	99146678, 88282865	<a href="mailto:dugarmaa0102@gmail.com">dugarmaa0102@gmail.com</a>
10	Хөвсгөл	В.Олдох	Аймгийн зохицуулагч	99382727	<a href="mailto:Tsendee8199@gmail.com">Tsendee8199@gmail.com</a>
11	Өвөрхангай	Д.Сугар	Аймгийн зохицуулагч	88193252, 88287908	<a href="mailto:Sugaraa.nandia@gmail.com">Sugaraa.nandia@gmail.com</a>
12	Сүхбаатар	Я.Эрдэнэ-Өлзий	Аймгийн зохицуулагч	99519292, 88280772	<a href="mailto:Erdeneulzii67@yahoo.com">Erdeneulzii67@yahoo.com</a>
13	Хэнтий	Ч.Мөнх-Эрдэнэ	Аймгийн зохицуулагч	99091302, 88280955	<a href="mailto:Mogi.chuka@yahoo.com">Mogi.chuka@yahoo.com</a>

Архангай аймгийн ХХААГ-ийн дарга А.ГОМБОДОРЖ:

## АРДЧИЛЛААС ХОЙШ МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ ХЭРЭГЖСЭН ХАМГИЙН ҮР ДҮНТЭЙ ТӨСӨЛ



“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийг 2012-2016 онд Архангай аймагт хэрэгжүүлсэн бол үргэлжлүүлэн Төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа билээ. Энэ талаар Архангай аймгийн ХХААГ-ийн дарга А.Гомбодоржоос тодрууллаа.



**-ЗЗБУХ төсөл хамгийн урт хугацаанд, үр дүнтэй хэрэгжиж буй аймаг бол танай аймаг. Төслийн үр дүнгээс хуваалцахгүй юу?**

Тийм ээ. Ардчилал эхэлснээс хойш манай мал аж ахуйн салбарт хэрэгжсэн хамгийн үр дүнтэй төсөл бол 1997 оноос хойш үе шаттай хэрэгжиж буй НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх Олон улсын сангийн санхүүжилттэй төсөл. Хөдөө аж ахуйн салбар тэр дундаа мал аж ахуйн салбарт маш их үр өгөөжөө өгч ирсэн. Тухайлбал малчдын амьжиргааг дэмжих, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, малчдын хүүхдийн нийгмийн асуудлыг шийдэх, мөн малчдад шууд бусаар үр ашгаа өгөх малыг эрсдэлээс хамгаалах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зэрэг олон чухал тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэсэн байдаг. Манай аймагт удаа дараа хэрэгжиж буй учраас үр өгөөж нь ч илүү гарч байгаа. Сумдад малчдын бүлгийг

байгуулж түүгээр дамжуулан мал аж ахуйн салбарт олон дорвитой ажлуудыг хийж хэрэгжүүлж байгаа. Тухайлбал худаг гаргах, мал угаалгын ванн барих, бэлчээрийн төлөвлөгөө гаргаж, хуваарьтай ашиглах, хамгаалах, өвс, тэжээл бэлтгэх, агуулах сав барих, хашаа хороо янзлах гээд яг л малчдад тулгамдсан олон асуудлуудыг шийдэж өгсөнд малчид их баяртай байгаа. 2012-2016 оны хооронд мал аж ахуйн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Батцэнгэл, Өгийнуур, Өлзийт суманд төсөл хэрэгжсэн бол Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Хайрхан, Төвшрүүлэх гэсэн дөрвөн суманд хэрэгжиж байгаа. Мөн энэ оноос хүрээгээ тэлж, аймгийн бүх суманд хүрч ажиллаж байна. 2020 онд манайд 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс тал хувийг нь худаг барихад зориулсан гэхээр малчдад ямар их хөрөнгө оруулалт хийсэн нь тодорхой. Өнгөрсөн онд гэхэд мал аж ахуйн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд аймгийн хэмжээнд 44 гүн өрмийн худгийг шинээр гаргаж, өвөлжилт хүндрэхэд төслийн сумдад 20 сая төгрөгийн өвс, тэжээлийн дэмжлэг үзүүлсэн нь малчид зудыг хохирол багатай даван туулахад томоохон тус дэм болсон. Үүнээс гадна сум бүрт 5-8 малчдын бүлэг байгуулж, дундын сан үүсгэн цаг хүндэрсэн үед ашиглах нөөцийг бүрдүүлж чадсан. Саяхан бас малчдын хоршоодод хөнгөлөлттэй зээл олгосон бол удахгүй ОХУ-аас оруулж ирсэн сайн чанарын малаар малынхаа удмын санг сайжруулахаар төлөвлөж байна. Малчдын бүлгүүдээс гадна эмэгтэйчүүд давамгайлсан бүлгүүдийг байгуулж өрхийн үйлдвэрлэлийг нь дэмжиж, сургалт явуулж, ажлын байраар хангасан нь урт, удаан хугацаанд оршин тогтнох чадвар суулгаж өгсөн.

**-Төслийн шугамаар байгуулагдсан бүлгүүд бүгд л үйл ажиллагаагаа өргөжүүлэн амжилттай явж буй нь төслийн нэг үр дүн болов уу?**

Ер нь бусад төслүүдийг хараад байхад зөвхөн төсөл хэрэгжих хугацаанд л ажил хийгдээд ганц,

хоёр жилийн дараа ямар ч үр дүнгүй л болдог. Харин энэ төслийн нэг давуу тал нь цаашид он удаан жил үргэлжлээд явахаас гадна байнга ашиглах, мал үйлдвэрлэлдээ өдөр тутам шахам хэрэглэгдэх нэн чухал хэрэгцээтэй зүйлийг шийдэж өгсөн учраас их үлдэцтэй, үр дүнтэй ажил болж байна.



**- Танай аймагт төслийн шугамаар хийгдсэн нэг онцлог ажил нь цаг уурын автоматжуулсан дамжуулах системийг сумдад суурилуулсан явдал. Үүний үр дүн хэр гарч байна вэ?**

Энэ одоогийн төслийн өмнөх шат буюу 2012-2016 оны төслийн хугацаанд хийгдсэн ажил л даа. Цаг агаарын мэдээг малчдад шуурхай хүргэх зорилгоор цаг уурын автомат систем суурилуулсан байгаа. Тодруулбал цаг агаарын мэдээг хиймэл дагуулаас шууд аваад сумын цаг уурын ажилтан, төслийн ажилтан хоёр малчдын гар утас руу шууд мессеж илгээж дамжуулдаг. Энэ нь Монголд хийгдсэн анхны ажил. Одоо манай малчид бүгд цаг агаарын урьдчилсан мэдээгээ хараад нүүдэл, суудлаа төлөвлөж, урьдчилсан сэргийлэх арга хэмжээ сайтар авч чадаж байгаагийн үр дүнд байгалийн гамшгийг харьцангуй хохирол багатай туулж чадаж байна.



АРХАНГАЙ АЙМАГТ

**2.8 ТЭРБУМ**  
**ТӨГРӨГИЙН**  
**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙГДЖЭЭ**

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил”  
Нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд  
Архангай аймгийн 19 суманд 2.8 тэрбум  
төгрөгийн 24 төрлийн ажил хийгдэж, төслийн  
үр шимийг хөдөөгийн иргэдэд хүртээж  
ажилласан байна.



2018 оноос хойш эмэгтэйчүүд  
давамгайлсан бүлгийн 451, БАМБ-ийн  
2412, ААН-ийн 50 гаруй, нийт 3000-аад  
хүн төсөлд хамрагдан үр шимийг нь  
хүртэж явна.



Төслийн хүрээнд Бэлчээр ашиглагч  
малчдын 24 бүлэг байгуулагдсан  
бол эмэгтэйчүүд давамгайлсан 54  
бүлэг байгуулагдан удаа дараагийн  
сургалтуудыг авсны үр дүнд мал аж  
ахуй, өрхийн үйлдвэрлэлээ амжилттай  
удирдан, байгаль орчноо нөхөн сэргээх  
олон үр дүнтэй ажлуудыг хийсээр байна.



Бог мал угаах 22 ванн  
шинээр баригдаж, 1834  
малчин өрхийн 686,276  
толгой бог мал угаалгад  
хамрагджээ. Мөн өвс,  
тэжээлийн агуулах  
саравч цөөнгүй тоогоор  
баригдаж, мал, малчид  
өвлийг эрсдэл багатай  
даван туулах нөхцөл  
бүрдэв.



Хөрөнгө оруулалтын  
үр дүнд нийт 17  
суманд инженерийн  
хийцтэй гүн өрмийн  
61 худаг шинээр  
баригдаж, 815 малчин  
өрх, 561,573 толгой  
мал, 93,510 га талбай  
усан хангамжаар  
хангагджээ.



Оготно устгах багаж, тоног төхөөрөмжийн  
дэмжлэгийг малчдад үзүүлсэний үр дүнд  
463,205 га бэлчээрийн талбайд устгал  
хийгдэж, бэлчээр дахин сэргэжээ.



Төсөл хэрэгжсэний үр дүнд 50 гаруй  
иргэн ажилтай болж, засварлаж өгсөн  
ажлын байранд 4 сумын 2 бүлгийн 16  
гишүүд болон 25 иргэн үйл ажиллагаагаа  
явуулж байна.



Эрсдэлийн санд 60 сая төгрөг  
төвлөрүүлж, түүнээсээ 87 тонн өвс, 18,7  
тонн тэжээлийг худалдан авч, нийт 612  
өрхөд нийлүүлэв.



2018 оноос хойш 12 иргэн 100 сая,  
9 аж ахуй нэгж 608 сая төгрөгийн  
хөнгөлөлттэй зээлд хамрагдан  
бизнесээ өргөжүүлэн ажиллаж  
байна.



## ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН “МОЙЛТ ХАЙРХАН” МАЛЧДЫН БҮЛГИЙН АХЛАГЧ Р.ГАЛБАДРАХ:

Нутаг ойролцоо 10 өрх төслийн шугамаар нэгдэж бүлэг болсон. Хэд, хэдэн удаагийн сургалтад сууж бэлчээрээ төлөвлөгөөтэй ашиглаж, хашиж хамгаалж сурлаа. Манайханд худаг ус их дутагдалтай байсныг төслөөс нэг худаг засварлаж, булаг хашаалж, мал угаалгын ванн барьж өгсөн нь бидэнд их том дэмжлэг болсон. Бас өнгөрсөн өвөл цаг хүнд үед өвс, тэжээлийн тусламж үзүүлсэнд их баяртай байгаа. Бүгдээрээ бас нийлж бүлэг болж ажилласнаар олон давуу тал үүсдэг юм байна. Жишээ нь бид мал хуйгаа нийлж ноослоод, тодорхой хэмжээний талбайд малын тэжээлийн ургамал тариалж байгаа.



## ХАЙРХАН СУМЫН “ОДОН СУУДАЛ” МАЛЧДЫН БҮЛГИЙН АХЛАГЧ Н.БАТСҮХ:

2020 онд ЗЗБУХТ-ийн шугамаар бэлчээр ашиглагч малчдын бүлгийг байгуулсан. Хамтарч мал аж ахуйгаа эрхлэхийн зэрэгцээ сургалтад сууж, 3 га газарт малын тэжээл тарьж, бас олон наст ургамал ургуулж байна. Төслийн сургалтад сууснаар бэлчээрийн менежментийн төлөвлөгөө гаргаж сурсан, дундын сан байгуулж түүгээрээ өвс, тэжээлээ базаадаг болсон. Манай сумын хэмжээнд нийт 8 бүлэг бий. Бүгд л идэвхтэй ажиллаж байгаа. Тэгэхээр төсөл их сайн хэрэгжиж байна гэсэн үг. Хамтарч хөдөлмөрлөсний үр дүн мэдээж их гарна шүү дээ.



## ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН “СОЧУ ТРАНС” ХХК-НИЙ ЗАХИРАЛ Б.ЧОЙДОГ:

Анх би ганцаараа 500-600 шувуутай аж ахуйгаа эхлэн өндөглөгчөө нэмэх санаа байсан ч чадахгүй байсан л даа. Тэгээд 2019 оноос эхлэн “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн шат дараалсан олон сургалтуудад сууж, төслөө бичээд бага хүүтэй, 50 сая төгрөгийн зээл авч, өндөглөгчийнхөө анхны заалыг барьж байлаа. Ер нь манай аймгийн хувьд төслийн хамгийн үр дүнтэй, бодитой анхны батлан даалттай зээл хэрэгжсэн нь манай аж ахуй л даа. Эхний зээлээ төлж дуусаад сая төслөөс 10 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламж үзүүлсэнд их баяртай байна. Төслийн сургалтуудад сууснаар бас би бизнесээ тогтвортой, амжилттай авч явах чадварыг эзэмшсэн. Одоо манайх 6000 өндөглөгч тахиатай, өндөглөгчийн 2, дэгдээхийний 1 заалтай, 5 хүнийг тогтмол ажлын байраар хангаж, аймгийнхаа тахиа, өндөгний хэрэгцээний 70 гаруй хувийг ханган ажиллаж байна. Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлж 10.000 өндөглөгчтэй болох төлөвлөгөөтэй байгаа. Ингэснээр аймгийнхаа өндөгний хэрэгцээг импортгүйгээр хангах боломжтой болно.





## ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН “Б” ЭМЭГТЭЙЧҮҮД ДАВАМГАЙЛСАН БҮЛГИЙН ГИШҮҮН Р.РИНА:

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн шугамаар 2019 онд бид бүлгээ байгуулсан, одоо 50 гишүүнтэй. Төсөлд хамрагдаж, сургалт суусны буянаар “Дундын сан”-тай болж, амьдрал ахуйдаа тус дэм болж явна. Сар бүрийн 15, 30-ны өдөр 32.000 төгрөг нийлүүлээд банканд хадгалуулчихдаг. Тэгээд жилийн эцэст мөнгөө аваад бараа материалаа авдаг. Мөн биднийг төслөөс ажиллах орчноор хангаж өгсөн. Хуучин захиргааны барилгыг тохижуулж өгч, бид одоо тэндээ үйлдвэрлэл, үйлчилгээгээ явуулж байгаа. Бас гурван ч удаа өөр аймаг руу явж сургалтад сууж, их туршлага хуримтлуулсан шүү.



## ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧ Д.АЛТАНТУЯА:

Өнгөрсөн 2020 онд төслийн сургалтуудад суусны үр дүнд бизнес төслөө амжилттай бичээд 75 сая төгрөгийн батлан даалттай зээл авсан. Одоо бараг төлөөд дуусаж байгаа. Анх би 1 ресторантай байсан бол одоо 2 салбартай, махны цехтэй, 34 хүнийг ажлын байраар ханган, ажиллаж байна. ЗЗБУХТ-ийн хамт олондоо орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, бизнесээ тогтвортой авч явах чадвар суулгаж, батлан даалттай бага хувийн, их дүнтэй хөнгөлөлттэй зээл олгож олон бичил бизнес эрхлэгчдийг дэмжиж буйд талархал илэрхийлье.



## ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН “ТЭЭЛИЙН ЭХ” БАМБ-ИЙН АХЛАГЧ Д.ТҮВШИНБАЯР:

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээнд 30 өрх бүлгийн зохион байгуулалтад орж ажиллаад 2 жил болж байна. Бэлчээрийн менежментийг сайжруулах, малын эрүүл мэнд, үржлийн чанар, дундын сан байгуулах гэх мэтчилэн олон сургалтуудыг авсны үр дүнд одоо бэлчээрээ сэлгэж ашиглаж, бэлчээрийнхээ хил хязгаарыг тодорхойлж газрын нэгдсэн санд бүртгүүлсэн. Бас бэлчээрийн гурван жилийн төлөвлөгөө гарган ажиллаж байгаа. Төслөөс бидэнд сургалт явуулахаас гадна гүн өрмийн худаг шинээр гаргаж, мал угаалгын ванн барьж өгсөн нь манай багийн олон малыг угаах боломжтой болсон.



## ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН ИНКУБАТОР ТӨВИЙН БОЙЖИГЧ Ч.БАДАМХАНД:

Би “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн шугамаар байгуулагдсан бизнес инкубатор төвд ногоогоор хийсэн олон төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, борлуулж, зоогийн газар ажиллуулдаг. Хүнсний ногоо тариалах, боловсруулах, хадгалах сургалтад нь сууж, сурч авсан мэдлэг дээрээ үндэслэн өрхийн аж ахуйгаа 2018 оноос эхлэн эрхэлж байна. Сургалт бүрийн үеэр хүмүүсээс ямар чиглэлээр сургалт авах хүсэлтэй байгаа саналыг нь авч дараагийн сургалтуудаа хийдэг учраас маш их үр дүнтэй байдаг. Оёдол, төсөл бичих, өрхийн аж ахуй эрхлэх, гар урлал гэх мэт маш олон төрлийн сургалтуудыг явуулсны үр дүнд манай сумын олон ажилгүй хүмүүс их зүйл сурч, өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа.



Өвөрхангай аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Гүнсэнхорол:

## ТӨСЛӨӨС МАЛЧДАД ХАМГИЙН ИХ ТУЛГАМДДАГ, ӨӨРСДИЙН ХҮЧЭЭР ХИЙХ БОЛОМЖГҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУДЫГ ХИЙЖ ӨГСӨН



ЗЗБУХТ-ийн хүрээнд хамгийн их бүтээн байгуулалтыг Өвөрхангай аймгийн 19 суманд хийсэн байдаг. Төслийн хэрэгжилтийн талаар аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Гүнсэнхоролтой ярилцлаа.

**-Танай аймагт ЗЗБУХТ хэрэгжиж эхэлснээс хойш нийт хэдэн төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээд байна вэ?**

Өвөрхангай аймагт ЗЗБУХТ-ийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа 2019 оны хавраас эхлэн тухайн ондоо төсөл болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр аймгийн барааны захын ил задгай худалдаа эрхлэгчдийг дэмжин 15 павильон барьж, ажлын байраар хангасан. Түүнчлэн 2020 онд 17 суманд инженерийн хийцтэй гүн өрмийн 22 худаг, 12 суманд мал угаалгын 16 ванн, Арвайхээр суманд “Өвөрхангайд үйлдвэрлэв” худалдааны төв, Хархорин суманд борлуулалтын цэг, Бат-Өлзий, Тарагт сумдад өвс, тэжээлийн агуулах саравч шинээр баригдаж, Бүрд, Хужирт, Есөнзүйл, Хайрхандулаан, Төгрөг, Тарагт сумдад засварын ажил хийгдэж, нийт 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Энэ онд 10 суманд инженерийн хийцтэй гүн өрмийн

17 худаг, 7 суманд мал угаалгын 11 ванн, Хужирт суманд борлуулалтын цэг, Тарагт суманд ажлын байр, Арвайхээр суманд 100 тоннын хүнсний ногооны зоорь, аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн агуулах шинээр барихад 911.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байна. Үндсэндээ малчдад хамгийн их тулгамддаг, өөрсдийн хүчээр хийх боломжгүй томоохон хөрөнгө оруулалтуудыг бараг бүгдийг нь хийсэн. Ер нь “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн хувьд орон нутгийн шийдвэр гаргах болон хэрэгжүүлэх оролцоог бүрэн хангаж, хөрөнгө оруулалтыг салбарын хэрэгцээнд тулгуурлан төлөвлөж, бүтээн байгуулалтын ажлуудыг хийдэг давуу талтай.

**-Харин мал аж ахуйн салбарт маш олон үр дүнтэй ажлууд хийгдэж, үр шимийг нь хүртсэн малчид ч их сэтгэл хангалуун байна лээ...**

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд манай аймгийн нийт нутгаар газрын гарц тааруу, малчид маань холын отор нүүдэл их хийж, чамгүй хүнд үеийг туулсан. Энэ үед төслийнхөн маань их тус дэм болсон л доо. Тухайлбал төслөөс Тарагт, Төгрөг, Хархорин сумдад өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх зориулалтаар тус бүр 20.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг үзүүлсэн. Түүний үр дүнд малчид байгалийн бэрхшээлийг харьцангуй хүндрэл багатай даван туулсандаа их баяртай байгаа. Мөн төслийн Бэлчээрийн удирдлага, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дээрх гурван сумдад малчдад зориулсан сургалт мэдээллийн төвийг тохижуулж, байгуулсны үр дүнд малчдын бүлгүүд сургалтад хамрагдаж, нэгдэж, бэлчээрийн төлөвлөлт гарган, худаг, уст цэгийг засварлах, булаг шандыг хашаажуулах, хортон мэрэгчтэй тэмцэх зэргээр хөдөлмөрөөрөө хоршин ажиллаж байна.

**-Төслийн шугамаар хийгдсэн хамгийн том бүтээн байгуулалт бол танай аймгийн төвд баригдсан**



**“Өвөрхангайд үйлдвэрлэв” төв. Тус төвд одоо хэдэн хэчнээн хүн, байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа вэ?**

Төсөлтэй хамтран “Өвөрхангайд үйлдвэрлэв” худалдааны төв, Хархорин суманд борлуулалтын цэгийг 295.3 сая төгрөгөөр шинээр барьсан. Үүний үр дүнд 90 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн 500 орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг шимтгэл авалгүй худалдаалж, үйлдвэрийн үнээр нь хэрэглэгчдэд хүргэж, одоогийн байдлаар 160 гаруй сая төгрөгийн борлуулалт хийгдсэн гэсэн судалгаа гарсан байна лээ.

**-Төсөл танай аймагт хэрэгжсэнээр гарсан гол үр дүнгүүдээс хуваалцаач...**

Төслийн хөрөнгө оруулалтаар хөдөө аж ахуйн салбарт бодитой, хэрэгцээ шаардлагатай, тулгамдаж буй олон ажлуудыг орон нутагт хийж байгаа. Тухайлбал бог малыг угаалгад хамруулах, эрүүлжүүлэх технологит ажил 70-90 хувь хийгдэж, бэлчээрийн усан хангамж 58.5 мянган га-гаар нэмэгдэж, 200 орчим тонн өвс, тэжээл нөөцлөх агуулах саравчыг шинээр барьж засварлааад байна. Мөн төслөөс малчин эмэгтэйчүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хамтарч үйлдвэрлэл эрхлэх, бүлэг байгуулахад сургалт, мэдээллээр хангаж, хөнгөлөлттэй зээлд хамрагдах болон зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэхэд дэмжлэг үзүүлж ирсэн. Сүүлийн жилүүдэд аймгийн хөдөө аж ахуйн салбарт улсын төсвөөс хуваарилагдсан хөрөнгөөс багагүй хөрөнгө оруулалтыг “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөс хийж, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлсэнд баяртай байна.



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ**

**2.7 ТЭРБУМ  
ТӨГРӨГИЙН  
САНХҮҮЖИЛТ ХИЙГДЭЭД БАЙНА**

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2019-2021 онд 19 суманд “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” Нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд нийт 2.8 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 1000 гаруй хүн шууд болон, шууд бусаар төслийн үр шимийг хүртжээ.



Төслийн шугамаар эмэгтэйчүүд давамгайлсан 37, бэлчээр ашиглагч малчдын 24 бүлэг тус, тус шинээр байгуулагдаж, нийт 300 гаруй иргэн төсөлд хамрагдаж, өрхийн үйлдвэрлэл, амьдрал ахуйгаа дээшлүүлжээ.



Өвөрхангай аймаг сүүлийн 6 жил мал сүргийн тоогоороо улсад тэргүүлж буй учраас бэлчээрийн даац 3-5 дахин хэтэрч, усны хомсдол үүссэн. Тэрхүү эрэлт, хэрэгцээг үндэслэн “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” Нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд 897 сая төгрөгөөр нийт 38 инженерийн хийцтэй гүн өрмийн худгийг барьж байгуулжээ. Мөн гурван худагт нарны панел шинээр суурилуулав.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” Нэмэлт санхүүжилт төсөл хэрэгжсэний үр дүнд Тарагт, Төгрөг, Хархорин суманд 76.509.000 төгрөгийг “Эрсдэлийн сан”-д төвлөрүүлээд байгаа юм.



Бүтээн байгуулалтын ажил хамгийн их хийгдсэн аймаг нь Өвөрхангай бөгөөд 210 гаруй сая төгрөгөөр 4 ажлын байр, 189 сая төгрөгөөр бизнес инкубатор төв, 130 сая төгрөгөөр хүнсний ногооны зоорийг тус, тус шинээр барьж байгуулж, 70 гаруй сая төгрөгөөр ажлын байруудыг засварлан орон нутгийн иргэдийн бичил бизнесийг дэмжиж, тав тухтай ажлын байраар хангажээ.



БАМБ, ЭДБ-ийн гишүүд болон иргэдэд зориулсан нийт 50 удаагийн сургалт зохион байгуулагдаж, 120 сая төгрөгийн батлан даалттай хөнгөлөлттэй зээлийг иргэдэд олгож бизнес, аж ахуйг нь дэмжжээ.



Төслийн хүрээнд 413 сая төгрөгөөр 40 мал угаалгын ванныг барьж, малчид болон малын эмч нарын хамгийн их тулгамдсан асуудлыг шийдэж, мал сүргийн эрүүл мэндийг хамгаалсан байна.



Өвс, тэжээлийн агуулах саравч 7 суманд барьж, Төгрөг суманд хадлангийн услалтын системийг бий болгож, 20 сая төгрөгийн үнэ бүхий өвс, тэжээлийн тусламжийг үзүүлснээр малчид өвөл хаврыг хохирол багатай даван туулахад томоохон дэмжлэг болсон билээ.



Төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа хэрэгжсэний үр дүнд нийт 127 ажлын байр шинээр бий болж, мөн тооны өрхийн амьдрал дээшилж, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулсан байна.



Малчдад нийт 22 сая төгрөг бүхий оготно устгалын төхөөрөмжийг шийдэж өгснөөр 60 мянган га нутаг дэвсгэрт оготно устгалын ажил хийгдэж, бэлчээр сэргэсэн үзүүлэлт гарчээ.



## АРВАЙХЭЭР СУМЫН “ӨВӨРХАНГАЙД ҮЙЛДВЭРЛЭВ” ТӨВД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ И.АЛТАНЦЭЦЭГ:

“Өвөрхангайд үйлдвэрлэв” төв байгуулагдсан цагаас хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа. Төслийн хөрөнгө оруулалтаар ийм сайхан тохитой, тухтай байрыг барьж байгуулж өгч, бас түрээсийн төлбөр авахгүй, үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнесийг нь дэмжиж буйд энд байгаа бүх хүмүүс маш их баяртай байдаг. Миний хувьд бас ЗЗБУХТ-өөс зохион байгуулсан Хөх хотын үзэсгэлэнд оролцоод ирсэн. Бараа бүтээгдэхүүнээ борлуулахын зэрэгцээ байнгын хэд, хэдэн харилцагч, худалдан авагч нартай болж, анх удаа бүтээгдэхүүнээ хилийн чандад худалдаалсан. Одоо захиалагч нартайгаа нягт холбоотой ажиллаж бүтээгдэхүүнээ явуулдаг.



## ТӨГРӨГ СУМЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧ Д.ОДОНЧИМЭГ:

Би 36 жил багшлаад 2018 онд тэтгэвэртээ гарсан. Тэгээд цайны газар ажиллуулахаар шийдэж, нээсэн ч тоног төхөөрөмж цөөнөөс болоод нэг их амжилттай явуулж чадахгүй байсан л даа. Харин 2019 оноос “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл манай суманд хэрэгжиж, олон удаагийн сургалтуудад суусны үр дүнд өрхийн аж ахуй эрхлэх, бичил бизнес эхлүүлэх, төсөл бичих, аж ахуйгаа амжилттай, тогтвортой авч явах гээд олон зүйлийг сурч авсан. Сурсан зүйл дээрээ тулгуурлаад бизнес төсөл бичээд шалгарч, 10 сая төгрөгийн зээл авч, бизнесээ өргөжүүлэх боломжтой болсон. Зээлээрээ махаа хадгалах хоёр том хөлдөөгч авч, мах болон түүхий эдээ хангалттай бэлдэж, хуушуурын тогоотой болж, цаашлаад машинтай болж, хүргэлтийн үйлчилгээ үзүүлж байна. Отор нүүдэл хийж яваа, ойр бас байшин барилга барьж буй хүмүүс хоол захиалдаг. Өмнө нь машингүйн улмаас хүргэж чаддаггүй байсан бол одоо унаатай хүргэж өгөөд, өөрөө аймгаас бараа материал, түүхий эдээ тагдаг болсон.



## ТӨГРӨГ СУМЫН БЭЛЧЭЭР АШИГЛАГЧ МАЛЧДЫН БҮЛГИЙН АХЛАГЧ Б.ТУНГАЛАГ:

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн шугамаар бид 2019 оны 6-р сард малчдынхаа бүлгийг байгуулсан. Малчин бидэнд зориулсан сургалт бараг байдаггүй гэж хэлж болно. Харин төслийн буянаар бид бэлчээрээ төлөвлөгөөтэй, сэлгэж ашиглаж, гурван жилийн бэлчээрийн менежментээ хийж, хамгаалж сурсан. Бас бид нар чинь жалгын нэг, нэгээрээ л нугаглаад тус, тусдаа л малаа маллаад явдаг, мал сурах болохоор л нэгнийхээрээ ордог байсан шүү дээ. Одоо бүлэг болсны буянаар бүх ажлаа хамжиж хийж, хамтраад бэлчээрээ ашиглаад өвс, тэжээлээ ч нийлж бэлтгэж байна. Манайхан бас хоёрхон гар худагтай, бас ус муутай, нэг нь бүр дарагдаад алга болчихсон олон жил худаг усны гачигдалтай байсан. Төслийн буянаар инженерийн хийцтэй, гүн өрмийн сайхан худагтай болж, хоёр гар худагаа хоёуланг нь гаргаж авч, одоо худаг усны асуудал, зовлонгүй болсон. Энэ төслийн нэг давуу тал нь биднээс юу хэрэгтэй байгааг байнга асуудаг. Бид нарт одоо өвс, тэжээлийн агуулах, сав хэрэгтэй байгаа. Саналаа өгчихсөн, удахгүй санхүүжилтийг нь шийдэж өгнө гэсэн. Төслийнхөндөө их баярлаж явдаг.







## ХАРХОРИН СУМЫН МАЛЧИН Г.ТӨМӨРБААТАР:

Хөдөө орон нутаг, ялангуяа говь нутгийнханд худаг, усны хэрэгцээ маш их байдаг. Гэвч хөрөнгө, мөнгөний дутагдлаас болоод худаг гаргаж чаддаггүй. Манай энэ хавь бэлчээр сайтай, ургамлын гарц сайн хэдий ч худаг ус ховор, хэдэн арван километр зам туулж, малаа тууж очиж усалдаг байсан. Арав гаруй айлын 4000 гаруй мал ганцхан хуучны эргүүлэгтэй худгаас ууна. Нөгөөх нь төд удалгүй л шавхчихдаг ёстой л зовлонтой байсан даа. Олон ч жил бид сум, орон нутгаас худаг гаргаж өгөөч гэж гуйсан. Харин энэ төслийн буянаар инженерийн хийцтэй, гүн өрмийн сайхан худагтай болж авсан. Тэгээд бас бензин шатахуун үрэх шаардлагагүй худагтаа нарны пенал суурилуулж өгсөн. Нартай өдрүүдэд тэндээсээ эх үүсвэрээ аваад л малаа усалчихна. Бүрхэг өдөр нь мотор асаагаад усаа татчихдаг юм. Олон, хүн малыг усаар хангасан төслийнхөндөө их баярлаж явдаг даа.



## ТАРАГТ СУМЫН “УРАН ТОМОО” БҮЛГИЙН АХЛАГЧ Ц.ЧАНЦАЛМАА:



Би насаараа мал малласан малчин хүн л дээ. 2001 оноос хойш малынхаа ноос, түүхий эдээр гар урлалын зүйл, Монгол гэрийн хэрэгслүүд, малын ногт, бурантаг хийж, утас ээрч борлуулдаг байсан. Харин “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл 2019 онд манай аймагт хэрэгжиж эхэлснээс хойш сургалтуудад сууж, Архангай, Дундговь аймагт болсон туршлага судлах уулзалт, сургалтад сууж их зүйл сурч авсан. Архангайн сургалтаас л гэхэд сүү, цагаан идээгээр олон төрлийн бүтээгдэхүүн хийж сурч, одоо дэлгүүрүүд болон энд, тэндэхийн үзэсгэлэн худалдаануудад бүтээгдэхүүнүүдээ нийлүүлж, борлуулдаг. Төслөөс бас өнгөрсөн жил 10 сая төгрөгийн, бага хүүтэй зээл аваад ажлын байраа засварлаж янзлаад тоног төхөөрөмж авч, өрхийн үйлдвэрлэлээ өргөжүүлж гурван хүн цалинжуулан ажиллуулж байна. Төслийн нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй 1, тэтгэврийн 1 хүний цалинг нь өгөөд ажиллуулдаг. Зээл авч үйлдвэрлэлээ өргөжүүлснээр бүтээгдэхүүн олноор үйлдвэрлэж, захиалагч ч нэлээд нэмэгдсэн.



## ХАРХОРИН СУМЫН “ХИШИГ БУЯН” БАМБ-ИЙН АХЛАГЧ, “ХАЙРХАНЫ ШИМ” ЭДБ-ИЙН АХЛАГЧ Р.ТЭГШЖАРГАЛ:



Төслийн үр шимийг ёстой л хүртсэн шиг хүртэж яваа хүмүүсийн нэг нь би. ЗЗБУХТ-ийн шугамаар байгуулагдсан хоёр төрлийн бүлгийг хоёуланг нь байгуулж ажиллаж байгаа. Тодруулбал “Хишиг буян” малчдын бүлгийн ахлагчаар ажиллахын зэрэгцээ бас “Хайрханы шим” эмэгтэйчүүд давамгайлсан бүлгийн ахлагчаар ажилладаг. Эмэгтэйчүүд давамгайлсан бүлгээ 2019 онд 8 гишүүнтэй байгуулсан. Одоо өрх толгойлсон 2 эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй 1 эрэгтэй нийлсэн нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Олон төрлийн сургалтад сууж, их зүйл сурч одоо бүгд л өөрийн гэсэн өрхийн жижиг үйлдвэрлэл эрхэлж байна. Харин малчдын бүлгээ анх 10 гаруй өрхийн бүрэлдэхүүнтэй байгуулж байсан бол одоо 25 өрх болсон. Төслөөс санхүүжилтийг нь гаргаад бид ашиглагдаагүй нэлээд удсан худгаа засварласнаар одоо 10 гаруй өрх, 5000 гаруй мал ууж байгаа. Хоёр бүлэг маань нягт холбоотой, нэгнийгээ дэмжиж, хөдөлмөрөө хоршиж ажилладаг. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон удаагийн үзэсгэлэнд амжилттай оролцож ирсэн.



Дундговь аймгийн ХХААГ-ийн дарга Б.МӨНХЖАРГАЛ:

## МАЛЧДЫН ХОТОНД, ГЭРТ НЬ “ЭЛЧ ТӨӨНҮҮЛСЭН” БУЯНТАЙ АЖИЛ...



Дундговь аймагт хөдөө аж ахуйн чиглэлийн хэд, хэдэн төсөл хэрэгжсэнээс хамгийн үр дүнтэй нь “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл байсныг үр шим хүртэгчид нь ярьж байлаа. Төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааны талаар ХХААГ-ийн дарга Б.Мөнхжаргалтай цөөн хором ярилцлаа.

**-Дундговь аймагт хөдөө аж ахуй, мал аж ахуй чиглэлээр ямар төслүүд хэрэгжиж байв. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл бусад төслөөс юугаараа давуу талтай вэ?**

Хэд, хэдэн төсөл, хөтөлбөр хэрэгжиж байсан ч хаагдаад нэг их удалгүй л төслийн хүрээнд хийгдсэн ажлууд дагаад унтарчихдаг л даа. “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн хувьд малчдад хүртээмжтэй, сумдад нэн шаардлагатай бүтээн байгуулалт, бодит хөрөнгө оруулалтыг хийж, бизнес эрхлэгчдийг дэмжиж батлан даалттай зээл олгож, ажлын байраар хангагдгаараа бусад төслөөс давуу талтай. Ерөнхийдөө товчхон дүгнээд хэлбэл малчдын хотонд, гэрт нь “элч төөнүүлсэн” буянтай ажил гэж энэ төслийг хэлмээр байна. Төсөл хэрэгжсэнээр бас дан ганц малчид гэхгүй, бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд өрхийн үйлдвэрлэлээ өргөжүүлж, бараа бүтээгдэхүүнээ гадаад, дотоодод

худалдаалах боломжтой болсон. Үүнийг дагаад орон нутгийн хөгжил бас дээшилж байгаа юм.

**-Төслийн томоохон хөрөнгө оруулалтуудаас дурдвал...**

Манай аймагт ЗЗБУХТ хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2018-2021 оны хооронд хөдөө аж ахуйд чиглэсэн 2.8 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн. Манай аймагт түүхэндээ ийм том хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөр өмнө нь хэрэгжиж байгаагүй. Өнгөрсөн гурван жилд гэхэд 14 суманд 33 инженерийн хийцтэй худаг, мал угаах ванн 27 шинээр баригдаж, сургалт мэдээллийн төв, өвс, тэжээлийн агуулах саравч, байр, хүнсний ногооны зоорь зэрэг зөвхөн бүтэн байгуулалтын ажилд 2,4 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

**-Орон нутагт тэр дундаа ус, ундарга муутай говийн мал, малчдад худаг шиг хэрэгтэй зүйл байхгүй. Ялангуяа танай аймгийн сумдад тун ч тулгамдсан асуудал шүү дээ. Харин төслийн шугамаар зөвхөн зорилтот сумд гэлтгүй аймгийн хэмжээнд шинээр 33 худаг гаргаж...**

Тийм ээ, Дундговь аймагт уст цэгийн хангамж 56%-тай байдаг. Зөвхөн худаг гаргаад зогсохгүй бас нарны пенал суурилуулж, 28 хуучин гар худгийг 14 сая төгрөгөөр засварлаж өгсөн. Үүний үр дүнд 31.000 бэлчээрийн талбайг усжуулж, 215 өрхийн 92.955 мал усаар хангагдсан сайхан мэдээ байна. Бас худаг гаргаснаар хашсан талбайдаа малын тэжээл тариалах боломж бүрдсэн. Түүнээс гадна мал аж ахуйн салбарт төслийн шугамаар олон үр дүнтэй ажил хийгдсэн. Тухайлбал мал үржлийн үйлчилгээний нэгжийг бод, бог малын палк метр, циркул метр, лент метрээр 100 хувь ханган, 2 сумыг бод, бог малын зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багаж тоног төхөөрөмжөөр хангасан. Мөн аймгийн хэмжээнд малд зохиомол хээлтүүлэг хийх явуулын пункт, бод мал жинлэх пүүг нийлүүлж 15 сумын ХАА-н мэргэжилтэнг багажаар хангаад байгаа. Сүүлийн жилүүдэд мал угаалгын ванны ашиглалтын хугацаа дуусч, угаах боломжгүй болсон. Харин төслийн буянаар 26 ваннтай болж,



малын паразит өвчний гаралт өмнөх жилүүдтэй харьцуулахад эрс багассан үзүүлэлт гарсан байна лээ.

**-Сүүлийн хоёр жил Дундговь аймагт цаг хүндэрсэн. Байгаль, цаг уурын хүндхэн үеийг даван туулахад төслөөс чамгүй их дэмжлэг үзүүлсэн талаар малчид талархан ярьж байна лээ...**

Яг цаг хүндэрсэн үед өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор сум тус бүрт 20 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, Эрдэнэдалай, Сайхан-овоо, Дэлгэрцогт сумдад “Эрсдэлийн сан”-г бий болгосноор сүүлийн хоёр жил малчид өвс, тэжээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан. Үүний үр дүнд манайхан цагийн хүнд үеийг хохирол багатай даван туулж чадсан. Цаашид яг эзэндээ хүрсэн, үр өгөөжтэй энэхүү төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна. Ганцхан хөдөө аж ахуй гэлтгүй олон өрх, бизнес эрхлэгчдийг дэмжиж орон нутгийн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулсан ХХААХҮЯ, С.Занданбал зохицуулагчтай ЗЗБУХТ-ийн хамт олон, мөн аймаг сумдын төслийн ажилтнууддаа Дундговь аймгийнхаа нийт малчид, тариаланчид, бизнес эрхлэгчдийнхээ өмнөөс гүн талархал илэрхийлье. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ТҮҮХЭНД АНХ УДАА**

**2.8 ТЭРБУМ  
ТӨГРӨГИЙН  
ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БАЙНА**

“Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааг ХХААХҮЯ-наас Дундговь аймгийн Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Сайнцагаан сумдуудад 2018 оноос хэрэгжүүлэн одоогийн байдлаар 2.8 тэрбум гаруй төгрөгийн ажил хийгдээд байна. Өмнө нь ийм өндөр төсөвтэй төсөл хэрэгжиж байгаагүй юм.



ЗЗБУХТ-ийн үр дүнд аймгийн хэмжээнд 1051 өрх бүхий 28 бэлчээр ашиглагч малчдын бүлэг, эмэгтэйчүүд давамгайлсан 42 бүлэг байгуулагдан нийт 18 удаагийн сургалтад хамрагдаж, мэдлэг мэдээлэл олж авч, чадваржсанаар бэлчээрээ төлөвлөгөөтэй ашиглаж, өрхийн үйлдвэрлэл өргөжиж, ашиг орлого нэмэгдэн нийт 653 төсөлд хамрагдан үр шимийг нь хүртэж явна.



Малчдыг мэдээллээр хангах, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор сургалт мэдээллийн 3 төвийг 15 сая төгрөгөөр тохижуулж, 151 сая төгрөгөөр 4 ажлын байрыг засварлаж, 382 сая төгрөгөөр борлуулалтын цэгийг шинээр барьж, 20 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжөөр хангажээ. Үүний үр дүнд 30 өрхийн 65 иргэн ажлын байраар хангагдсан байна.



Төслийн санхүүжилтээр 24 сая төгрөгийн оготно устгах багаж буюу үлий цөмлөгч, мөн утагч нийт 60 ширхэг, 120 сая төгрөгийн өртөг бүхий мал үржлийн ажлын иж бүрэн багаж тоног төхөөрөмжөөр 15 сумын ХАА-н мэргэжилтэнг хангав. Үүний үр дүнд Сайнцагаан сумын “Сайнцагаан омог”-ийн хонинд зохиомол хээлтүүлэг хийгдэж, малын чанар сайжруулах ажилд үр дүнгээ өгч, 48000 га-д оготно устгах ажил хийгдэж бэлчээр сэргэжээ.



БНХАУ-д зохион байгуулагдсан “Экспо”-д аймгийн бизнес эрхлэгчдийн зардлыг ЗЗБУХТ-өөс хариуцаж бараа, бүтээгдэхүүнээ сурталчлан таниулж, хил дамнан борлуулалт хийж ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжоор хангаснаас гадна 1 ААН, 4 иргэнд “бар код” олгож бараа бүтээгдэхүүнээ борлуулах боломжийг бүрдүүлсэн юм.



Говь нутгийн мал, малчдад хамгийн их тулгамддаг худаг, усны асуудлыг шийдэж, 14 суманд инженерийн хийцтэй 33 худгийг 739 сая төгрөгийн хөрөнгөөр барьж өгснөөс гадна малчдын бүлэгт энгийн уурхай худгаа засварлах 14 сая төгрөгийг сумын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлснээр малчид 28 худгийг засварлаж, олон мянга хүн, мал ундаалж байна.



Мал, амьтныг халдваргүйжүүлэн ариутгах 27 мал угаалгын вангыг 14 суманд шинээр барьж, 1089 өрхийн 157874 толгой бог малыг угаалгад хамруулж, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэв.



Дундговь аймаг 1990 оноос хойш аймгийн аюулгүй нөөцөө хадгалах өвс, тэжээлийн агуулах байхгүй, жил бүр түрээс төлж өвс, тэжээлээ хадгалдаг байсан бол төслийн хүрээнд 515 сая төгрөгөөр 3 өвс, тэжээлийн агуулах саравч шинээр барьж, 2 агуулахыг засварлаад байна.

## САЙНЦАГААН СУМЫН “АРВИН САН” ЭМЭГТЭЙЧҮҮД ДАВАМГАЙЛСАН БҮЛГИЙН АХЛАГЧ Ц.ОЮУНЧИМЭГ:



ЗЗБУХТ-ийн хүрээнд 2019 онд 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бүлгээ байгуулсан. Бид эсгий гар урлал, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй, цагаан идээ боловсруулах зэрэг тус, тусын үйлдвэрлэлийг эрхэлдэг. Бичил үйлдвэрлэлтэй, ашиг орлого тийм ч их биш болохоор банкнаас зээл гарахгүй, барьцаа хөрөнгөгүй учраас өөрсдийн байгаа материалаараа гар аргаар цөөхөн хэдэн зүйл хийдэг байсан л даа. Харин төслийн буянаар батлан даалт гаргуулж 10 сая төгрөгийн зээл авч, тоног төхөөрөмжөө сайжруулан түүхий эд материалаа ч хангалттай татаж үйлдвэрлэлээ өргөжүүлсэн. Түүнээс гадна олон сайхан сургалтуудад сууж, гурван ч аймаг явж сургалтад хамрагдаж ур чадвар эзэмшсэн. Бас нэг хамгийн том дэмжлэг нь ажлын байр тохижуулж өгч, түрээс төлөхгүй үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн бүтээгдэхүүндээ “бар код” авсан. Ингээд үндсэндээ бидний бизнесийг төслөөс бүх талаар дэмжиж өгсөнд маш их баярлаж байна.



## ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН “ТЭНХЛЭГЭ ЗҮҮН” БАГИЙН МАЛЧИН, БАМБ-ИЙН АХЛАГЧ Л.БАТБОЛД:



Багийнхаа 66 өрхийг нэгтгэн 2019 онд төслийн зөвлөмж, заавар, сургалтад хамрагдсаны үндсэн дээр бүлгээ байгуулан гурван жилийн төлөвлөгөө боловсруулан, газрын нэгдсэн системд бүртгүүлэн, бэлчээрээ зөв зохистой ашиглаад явж байна. Бүлэг болсноор малчин бидний хоорондын хамтын ажиллагаа сайжирч, ажил, хөдөлмөрөө хамжаад амжуулчихдаг болсон. Гүн өрмийн 1 худаг гаргаж өгч, бас нэг гар худгийн засварын зардлыг төслөөс шийдэж, мөн бог мал угаадаг ванн барьж өгсөн. Өмнө нь 5-10 км малаа тууж ганц худгаас усалдаг, бас хаа байсан багийн төв рүү малаа тууж аваачиж угаалгадаг байсан. Одоо бол 5 хүрэхгүй км яваад л малаа усалчихна, усны ундарга нь ч хангалттай сайхан болсонд бид их баяртай байгаа.



## ДЭЛГЭРЦОГТ СУМЫН “НОГООН СУВД” ЭМЭГТЭЙЧҮҮД ДАВАМГАЙЛСАН БҮЛГИЙН АХЛАГЧ Ч.ДОРЖПҮРЭВ:



Манай аймагт төсөл хэрэгжиж эхэлсэн цаг үеэс л бид сургалтад сууж, бүлгээ байгуулан өрхийн үйлдвэрлэлээ өргөжүүлээд явж байна. Нийт 8 гишүүнтэй хүлэмжийн аж ахуй, оёдол, сүү цагаан идээ зэрэг үйлдвэрлэл явуулдаг. Төслийн шугамаар Хэнтий, Булган, Архангай аймгуудад болсон сургалтад хамрагдаж, бас төслийн зардлаар БНХАУ-ын Бээжин хотод болсон экспод оролцож, олон харилцагчтай болж, бараа бүтээгдэхүүнээ борлуулаад ирсэн. Бас ЗЗБУХТ-ийн сургалтад суусны үр дүнд бизнес төсөл бичиж сурсан. Удахгүй бүлгээ хоршоо болгож, батлан даалттай зээл авч бизнесээ өргөжүүлэх зорилготой ажиллаж байна даа.





### САЙНЦАГААН СУМЫН ЭДБ-ИЙН ГИШҮҮН, ТӨСЛИЙН АЖЛЫН БАЙРАНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ Д.НЯМСҮРЭН:

Тэтгэврийн хэдэн эмэгтэйчүүд бид гэр, гэртээ тодорхой хэмжээнд гар урлал эрхлээд явдаг байлаа. Харин 2019 онд ЗЗБУХТ манай суманд хэрэгжиж, бид бүлэг болон хамтраад хөдөлмөрлөөд явж байна. Төслөөс биднийг ажлын баяраар хангаж, олон сайхан сургалтад суулгаж, тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламжаар хангаж өгсөн. Одоо батлан даалттай зээлд хамрагдах гээд бид хэд нийлээд төсөл бичиж байна.



### САЙХАН-ОВОО СУМЫН МАЛЧИН, “БАНУУН МААНЬТ” БАМБ-ИЙН ГИШҮҮН Ж.НЯМСАНАА:

Олон жил ганц, хоёр айл саахалтаараа нутаглаж явж байгаад 2019 онд төслийн шугамаар 39 өрх нийлж бүлэг болсон. Бүлэг болсноор олон давуу тал гардаг юм байна. Мал хуйгаа ээлжлээд харчихна, ноос, ноолуураа нийлээд авчихна, бэлчээрээ бас сэлгэж ашиглаж сурч байна. Мөн “Дундын сан”-тай болж 17 сая төгрөг төвлөрүүлж чадсан. Энэ бүгд төслийн л буян л даа. Бидэнд олон сургалтууд явуулж, бэлчээрийн менежментийн 3 жилийн төлөвлөгөө боловсруулж сургаснаас гадна гүн өрмийн худаг гаргаж, мал угаалгын ванн байгуулж өгсөн. Манай сум чинь 1990 оноос хойш ванггүй байсан ш дээ. Энэ мэтээр бидэнд яг хэрэгтэй олон зүйлийг шийдэж өгсөн.



### ДЭЛГЭРЦОГТ СУМЫН “ХОНГОР” БАМБ-ИЙН АХЛАГЧ Н.ЗАГДСҮРЭН:

Манай бүлэг төслийн хүрээнд байгуулагдаад гурван жил болж байна. Анх 15 хүний бүрэлдэхүүнтэй гэрт хурлаа хийгээд эхэлж байсан бол одоо 40 гаруй өрхийг багтаасан багийн хэмжээний бүлэг болж өргөжсөн. Хөдөлмөрөө ч маш сайн хоршиж чаддаг болсон байна. Төслөөс гүн өрмийн худаг гаргаж өгсөн нь бас олон айл, мал усалж байгаагаас гадна “Дундын сан” бий болгоход ихээхэн дэмжлэг үзүүлсэн.



### ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН “ДАЛАЙ” ЭМЭГТЭЙЧҮҮД ДАВАМГАЙЛСАН БҮЛГИЙН ГИШҮҮН Т.ЭНХСАЙХАН:

Би нэлээд хэдэн жил гэртээ дээл, хувцас хийсэн л дээ. Харин жилийн өмнөөс манай суманд ЗЗБУХ төсөл хэрэгжиж, бүлэгт орж, төслөөс ажлын байр тохижуулж өгсөн. Одоо тохь тухтай байранд түрээс төлөхгүй үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн төслөөс явуулсан олон төрлийн сургалтад сууж хувь хүний хувьд хөгжиж, бичил үйлдвэрлэлээ ч амжилттай явуулахад ихээхэн тус, дэм болсон.



Дорнод аймгийн Засаг даргын орлогч, Төсөл удирдах ажлын хэсгийн дарга Ч.ГАНБАТ:

## АЙМГИЙН НИЙТ МАЛЧДЫН 50 ХУВЬ НЬ ТӨСӨЛД ХАМРАГДАЖ, БҮХ СУМДАД БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ХИЙГДЭЭД БАЙНА



Дорнод аймагт “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн санхүүжилтээр мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн олон арга хэмжээ, бүтээн байгуулалтууд хийгдэж буй. Төслийн үр дүнгийн талаар Дорнод аймгийн Засаг даргын орлогч, Төсөл удирдах ажлын хэсгийн дарга Ч.Ганбатаас тодрууллаа.



**-ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа танай аймагт хамгийн өндөр дүнтэй хэрэгжиж байгаа. Төслийн үр дүнгийн талаар дурдвал...**

Манай зүүн аймгууд руу мал аж ахуйн чиглэлийн төсөл, хөтөлбөр ер нь ховор хэрэгждэг л дээ. Харин 2018 оноос эхэлсэн “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа 14 сумыг хамран хэрэгжиж, мал аж ахуй тэр дундаа бэлчээр, малчид, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд нэн шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг хийж ирсэн. Үүний үр дүнд орон нутгийн иргэдийн оролцоо, идэвх сайжирч, 1990 оноос хойш хийгдээгүй олон бүтээн байгуулалтуудын ажлууд хийгдсэнд баяртай байна.

**-Танай аймгийн хамгийн алслагдсан, Улаанбаатар хотоос 1000 гаруй километрийн зайд орших Халхгол сум төслийн зорилгод нутагт багтсан. Үүнээс харахад төслийн хүрээ зах хязгаарын хилийн суманд хүрч, үр өгөөжөө өгч буйд нутгийн ард олон их баяртай байна лээ...**

Харин манай Халхголынхон их баяртай байгаа. Бид ч бас тэднийхээ өмнөөс төслийнхөндөө баярлаж, талархсанаа илэрхийлмээр байна. Манай аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбар нь ХАА-н салбар. Санаснаар болдог бол тус салбарт ажиллаж буй 6000 гаруй малчдыг бүгдийг нь энэ төсөлд хамруулж, амьдрал ахуйг нь дээшлүүлж, тулгамдсан асуудлуудыг нь шийдмээр байв ч, тийм боломжгүй юм даа. Гэхдээ төслийн хөрөнгө оруулалт бүх сумдад хийгдэж, малчдын 50 хувь нь үр шимийг нь хүртээд байгаа. Энэ бол хэрэгжиж байсан төсөл, хөтөлбөрийн хувьд аймгийн түүхэнд гарч байгаагүй өндөр үзүүлэлт, үр дүн юм. Манайх хойд, урд хөрштэйгөө 5 боомтоор хиллэдэг, бэлчээрийн мал аж ахуйтай, алслагдсан аймаг. Мөн отрын гол бүс нутаг учир хүний, өөрийн нийлсэн 3 сая гаруй толгой мал нутагладаг. Тиймээс бэлчээр доройтох, усан хангамж муудах, малчдын эрүүл мэнд, цаашлаад хүнсний аюулгүй байдалд асуудал тулгарч эхэлсэн. Төслөөс эдгээр асуудлуудыг үндэслэн сүүлийн хоёр жилд гэхэд 39 гүн өрмийн худаг шинээр гаргаж, мал угаалгын 16 ванныг барьж, байгууллаа. Түүнчлэн сумдын 50 хувьд нь өвс, тэжээлийн агуулах саравч барьж өгсний зэрэгцээ нөөц бүрдүүлэх асуудалд онцгой анхаарал хандуулсны үр дүнд 2019, 2020 оны жил дамнансан чанга өвлийг малчид маань малын гарз хохирол багатай даван туулсан.

**-Төслөөс 70 хувь, орон нутгаас 30 хувийг нь санхүүжүүлж буй нь орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлж, төслийн үр дүнг урт удаан хугацаанд үргэлжлүүлэх үндэс, суурь болж байх шиг байна...**

Тэгэлгүй яах вэ. Орон нутгийн оролцоог хангах бол хамгийн цагаа олсон зөв менежмент. Өмнө нь төслөөс 100 хувь санхүүжилтийг гаргадаг байсан бол орон нутгийн оролцоо, идэвхийг хангах үүднээс энэ оноос эхлэн аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-гаас 364 сая төгрөгийг анх удаа батлуулж, 2021 онд 1,4 тэрбум төгрөг төлөвлөсөн. Үүнээс мөн 30 хувийг нь буюу 8 төрлийн арга хэмжээг “Орон нутгийн хөгжлийн сан”-гаас санхүүжүүлэхээр төлөвлөн ажлууд хийгдээд явж байна. ЗЗБУХТ-ийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл нийт 3,2 тэрбум төгрөгөөр 50 төсөл, арга хэмжээг хийж, хэрэгжүүлээд байгаа. Үүнээс 800 сая төгрөгийг аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-гаас гаргасан. Орон нутгаас санхүүжилт гаргахаар оролцоо, харилцаа сайжрахаас гадна яг хэрэгцээ шаардлагатай, нэн тэргүүнд тулгамдаж буй зүйлдээ хөрөнгө оруулж чаддаг юм байна. Тухайлбал хүнсний зоорь, өвс, тэжээлийн агуулах, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих төв, ажлын байр, хүлэмжийн аж ахуй гэх мэтээр ард иргэдийн амьдрал ахуйд нэн хэрэгцээтэй асуудлуудыг шийдэж чадлаа. Энэ утгаараа бусад төслүүд зөвхөн хугацаандаа хэрэгжээд л дуусдаг бол энэхүү төсөл маань цаашаа үргэлжлээд явах үр дүн, онцлогтой. Мөн малчид ч бас өөрсдийн хувь оролцоог маш сайн бүрдүүлж байна. Тухайлбал малчны бүлгүүд “Дундын сан” бий болгож, түүндээ 20 гаруй сая төгрөг төвлөрүүлж, цаг хүндэрсэн үед ашиглахаар эрсдэлийн хөрөнгө бүрдүүлээ. Энэ бол төслийн бодит үр дүн. Малчдаас гадна бичил бизнес эрхлэгчид ч төслийн буянаар өргөжиж, амьдрал ахуй нь дээшилж буй олон сайхан жишээ бий. Тухайлбал төслийн шугамаар байгуулагдсан Халхгол сумын эмэгтэйчүүд давамгайлсан бүлгийн гишүүд олон удаагийн сургалтад суусны үр дүнд нутагт нь үйл ажиллагаа явуулдаг газрын тосны компанид 1 тонн зөгийн бал борлуулсан байх жишээтэй. Энэ мэтээр төслийн үр дүн гарсаар байна.



**ДОРНОД АЙМАГТ**  
**3.2 ТЭРБУМЫН**  
**ХӨРӨНГӨ**  
**ОРУУЛАЛТ**  
**ХИЙГДЭЖ, 1047 ӨРХИЙН**  
**2917 ХҮН ТӨСЛИЙН ҮР**  
**ШИМИЙГ ХҮРТЭЭД БАЙНА**

ХХААХҮЯ-аас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл болон аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 1,2 тэрбум төгрөг, 2021 онд 1,4 тэрбум төгрөгийн нийт 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тус хөрөнгө оруулалт Дорнод аймагт хийгдэж дууссанаар 14 сумын 1354 малчин өрхийн 545.422 толгой мал, 1414 малчин, 51 эмэгтэйчүүдийн бүлгийн 388 гишүүд төсөлд хамрагдаж, үр шимийг нь хүртэх юм. ЗЗБУХТ хэрэгжиж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл 3,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 1047 өрхийн 2917 хүн төслийн үр шимийг хүртээд байна.



Бэлчээрийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд бэлчээр ашиглагчдын малчдын бүлэг /БАМБ/ Халхгол /9/, Хөлөнбуйр /5/, Сэргэлэн /9/ сумдад нийт 23 байгуулагдаад байна. Эдгээр бүлгүүдэд 329.830 толгой мал бүхий 648 малчин өрх багтаж, төслийн үр шимээр мал аж ахуйгаа амжилттай төлөвлөн авч явна.



Зах зээлийн хөгжил бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд эмэгтэйчүүд давамгайлсан бүлэг Хэрлэн /24/, Халхгол /9/, Хөлөнбуйр /10/, Сэргэлэн /8/ нийт 51 бүлэг байгуулагдсан бөгөөд нийт 388 гишүүний 21,8 хувь нь өрх толгойлсон эмэгтэй бол 10,3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүд байгаа юм. Төсөл хэрэгжсэнээр гишүүд 10 гаруй удаагийн сургалтад сууж, хоёр ч удаа хилийн чанадад үзэсгэлэн худалдаанд оролцож туршлага хуримтлуулан, 13 иргэн ажлын байраар хангагджээ.



2019-2021 онд 14 суманд 897 сая төгрөгөөр 39 инженерийн хийцтэй худаг барьж байгуулснаар 143 өрхийн 92.120 толгой мал усан хангамжаар хангагдаж, бэлчээрийн усан хангамж 5 дахин нэмэгдсэн байна.



Төслийн 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 7 суманд өвс, тэжээлийн агуулах, саравч шинээр барьж, 6 жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв буюу ажлын байрыг барьж, засварлан, 2 хүнсний ногооны зоорь барьж, 3 малчдын сургалт мэдээллийн танхимыг тохижуулжээ. Үүний үр дүнд өвс, тэжээлийн хадгалалтын горим алдагдаж чанарт муугаар нөлөөлөх эрсдэлийг бууруулж, ажлын байр нэмэгдэхийн зэрэгцээ үйлдвэрлэл эрхлэгчид түрээс төлөхгүйгээр тав тухтай орчинд үйлдвэрлэл үйлчилгээгээ явуулж, бараа бүтээгдэхүүнээ борлуулан ашиг орлогоо нэмэгдүүлэх өргөн боломжийг бүрдүүлсэн байна.



Нэгдэл нийгмийн үеэс хойш бог мал угаах ваннгүй байсан тус аймагт 2019-2020 онд төслийн 192 сая төгрөгийн санхүүжилтээр 9 суманд 16 ваннг барьж, байгуулав. Жилийн хугацаанд 16 ваннг ашиглалтад оруулсны үр дүнд 1211 өрхийн 453,302 толгой бог малыг угаалгад хамруулж, мал амьтныг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлээд байна. Энэ онд мөн 9 суманд 10 бог мал угаах ванн шинээр барих юм.



Дорнод аймагт анх удаа 36 сая төгрөгийн үнэ бүхий малын цусны биохимийн аппаратыг төслийн санхүүжилтээр нийлүүлснээр сүүлийн үед үхэр сүрэгт зонхилон тохиолдож буй бодисын солилцооны дутагдлыг хугацаа алдахгүй оношлох боломжтой болсон юм. Түүнээс гадна 9.3 сая төгрөгийн өртөг бүхий 12 оготно устгах төхөөрөмжийг олгосноор нийт 17500 га талбайд устгал хийгдэж, мөн төслийн санхүүжилтээр бэлчээр ашиглагчдын малчдын бүлгүүдэд гал унтраагч моторыг шийдэж өгч, гал түймрийн аюулыг хохирол багатай даван туулах нөхцөлийг бүрдүүлэв.

## ХЭРЛЭН СУМАН ДАХЬ “МОДУН ШАНЬЮЙ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ж.ОЮУН-ЭРДЭНЭ:



Манай аймагт анх төсөл хэрэгжсэн үеэс л сургалтуудад нь идвэхтэй сууж, өнгөрсөн жил урт хугацаатай, хүү багатай, 75 сая төгрөгийн батлан даалттай зээлд хамрагдаж, 40/10-ийн харьцаатай хүлэмжийн аж ахуй байгуулан, цаг агаараас хамаарахгүй тариалалтаа эрхлэх болсондоо их баяртай байгаа. Бас зээл авсны үр дүнд ажлын байраа нэмэгдүүлж, одоогоор 26 хүнийг цалинжуулан, аймгийн төвийн хүнсний ногооны хэрэгцээний 30-аад хувийг дангаараа ханган ажиллаж байгаагаас гадна хүнсний ногооныхоо нэр төрлийг нэмэгдүүлсэн. Жижиг аж ахуй, бизнес эрхэлдэг бидэнд яг хэрэгтэй ЗЗБУХТ шиг олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлбэл улс орон их хурдан хөгжинө дөө.



## ХАЛХГОЛ СУМЫН СУМЫН “ЦАГААНУУР” БАМБ-ИЙН АХЛАГЧ Т.БАТХУЯГ:



Төслийн хүрээнд байгуулагдсан анхны малчны бүлгүүдийн нэг нь манайх. Анх 26 өрхтэй байсан бол одоо 32 өрх болж өргөжөөд байна. Төсөлд хамрагдаж, бүлэг болсны давуу тал нь бэлчээрийн гурван жилийн төлөвлөгөө гаргаж, газрын нэгдсэн санд бүртгүүлж, хадлан авах, түүхий эд бэлтгэх, хашаа хороо засварлах гэх мэт мал аж ахуйн бүхий л ажилд хамтаараа зүтгэдэг. ЗЗБУХТ-өөс бог мал угаалгын 2 ванн шинээр барьж, гүн өрмийн мөн 2 худаг гаргаж өгч, булаг хашаалж, хамгаалахад бас дэмжлэг үзүүлсэн. Мөн төслийн сургалтад сууж, зөвлөсний дагуу эрсдэлтэй үед ашиглах “Дундын сан”-тай болж, чамгүй хэмжээний мөнгө төвлөрүүлээд байгаа.



## ХАЛХГОЛ СУМЫН “БАЯЛАГ БҮТЭЭГЧИД” ЭДБ-ИЙН ГИШҮҮН, ЗӨГИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ Г.ЭНХЧИМЭГ:



Миний хувьд 2000 оноос хойш зөгий маллаж, 2019 онд “Баялаг бүтээгчид” ЭДБ-ийн гишүүнээр элссэн. Хувиараа өрхийн аж ахуй эрхэлж байгаад бүлгийн зохион байгуулалтад орсноор хийсэн бүтээгдэхүүн маань олонд танигдаж, тэр хэрээр борлуулалт нэмэгдэж, ашиг орлого өссөн. Бас олон төрлийн сургалтуудад гурван ч аймаг явж хамрагдаж, бизнесээ тогтвортой, амжилттай авч явахад суралцсанаас гадна төслөөс 2 удаа 5 сая төгрөгийн зээл авч зөгийн аж ахуйгаа өргөжүүлж, өмнө нь 50 бүл зөгийтэй байсан бол одоо 140 болж нэмэгдсэн. Мөн зээлээрээ цагаан идээний шинэ үйлдвэрлэлийн бизнес эхлүүлсэндээ их баяртай байна.







### СЭРГЭЛЭН СУМЫН “ТЭВШИЙН УХАА” БАМБ-ИЙН АХЛАГЧ П.ГАРМАА:

ЗЗБУХТ-ийн шугамаар 2019 онд бүлгээ байгуулсан. Төслөөс сургалт явуулж, бог малын ванн барьж, гүн өрмийн худаг гаргаж өгснөөс гадна малчдад нэн шаардлагатай сүүлийн үеийн өндөр хүчин чадалтай гал унтраах мотор, оготно устгах төхөөрөмжүүдээр хангаж өгсөнд малчид бид их баяртай байгаа. Манай тал нутагт хамгийн аюултай зүйл гал түймрийн аюул байдаг. Төслөөс төхөөрөмжөөр бүрэн хангасан нь галын аюулыг хохирол багатай даван туулахад маш том тус дэмжлэг болсон.



### ХӨЛӨНБУЙР СУМЫН “БОЛОР УНДАРГА” ЭМЭГТЭЙЧҮҮД ДАВАМГАЙЛСАН БҮЛГИЙН АХЛАГЧ Г.АЛТАНГЭРЭЛ:

Би 1990 оноос хойш хүнсний ногоо тариалж, 30 жилийн дараа төслийн буянаар хүлэмжтэй болсон. 2019 онд манай суманд төсөл анх хэрэгжиж эхлэх үед 5 эмэгтэйтэй хамтран бүлгээ байгуулж байлаа. Одоо наймуулаа болж өргөжсөн. Ганц хүнсний ногоо гэлтгүй төслөөс зохион байгуулсан олон төрлийн сургалтад сууж, бүлгийн гишүүд маань чадваржиж, зарим нь өрхийн жижиг үйлдвэрлэлээ нээх хэмжээнд хүрсэн байна.



### ХЭРЛЭН СУМЫН “БАЯЛАГ-ӨГӨӨЖ” ЭМЭГТЭЙЧҮҮД ДАВАМГАЙЛСАН БҮЛГИЙН АХЛАГЧ П.БАТЦЭЦЭГ:

“Баялаг-Өгөөж” ЭДБ-ээ 2019 онд төслийн шугамаар байгуулж, олон удаагийн сургалтад хамрагдсаны үр дүнд бүлгийн гишүүд өөр, өөрсдийн өрхийн үйлдвэрлэлээ амжилттай эрхлээд явж байна. Бүгдээрээ л их, бага хэмжээгээр төслийн үр шим хүртэж яваа. Надад гэхэд төслөөс 9 бүтээгдэхүүнд маань “бар код” авахад дэмжлэг үзүүлсэнд маш их баяртай байна. Код авснаар дэлгүүр, супермаркетуудаар бараа, бүтээгдэхүүнээ борлуулах эрхтэй болж, ашиг орлого тэр хэрээр нэмэгдсэн.



### ХӨЛӨНБУЙР СУМЫН “АРВИЖИН ДЭЛГЭРЭХ” ЭМЭГТЭЙЧҮҮД ДАВАМГАЙЛСАН БҮЛГИЙН АХЛАГЧ Ж.БАТДЭЛГЭР:

Манай бүлэг анх малчин бүсгүйчүүдийг ашиг, орлоготой байлгах, ажил, хөдөлмөрийг нь дэмжих зорилгоор 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Малчин эмэгтэйчүүдээс сүүт нь худалдан авч, бүтээгдэхүүн хийдэг. ЗЗБУХТ-ийн олон удаагийн сургалтуудад суусны үр дүнд эдийн засгийн суурь мэдлэгтэй болж, бүтээгдэхүүнүүдээ чанаржуулж, нэр төрлийг нь нэмэгдүүлж, маркетингаа илүү сайжруулсан. Үүний үр дүнд бүтээгдэхүүний борлуулалт сайжирч, ашиг орлого нэмэгдсэнд их баяртай байна. Одоо батлан даалттай зээлд хамрагдаж, тоног төхөөрөмжөө сайжруулах төлөвлөгөөтэй байгаа.



Сүхбаатар аймгийн ХХААГ-ын дарга Т.ГАН-ОЧИР:

## ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ХӨРС СУУРИНД ХӨГЖЛИЙН МАШ ТОМ ТУЛГУУР БАГАНЫГ БОСГОЖ ЧАДЛАА



“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа Сүхбаатар аймагт 2018 оноос эхэлж, 2021 оны 10 сарын сүүлийн байдлаар төслөөс нийт 3.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийгээд байгаа билээ. Нийт санхүүжилтийн 90 гаруй хувийг мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулсан байна. Төслийн хөрөнгө оруулалт, үр дүнгийн талаар аймгийн ХХААГ-ын дарга Т.Ган-Очирос тодрууллаа.



**-Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй хамгийн үр дүнтэй төслүүдийн нэг “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа танай аймгийн 4 суманд хэрэгжиж буй. Төслийн үр дүн ч сайн гарч байх шиг байна...**

Тийм ээ, үр дүн маш өндөр байгаа. Төслийг зорилтот дөрвөн суманд хэрэгжүүлж байгаад өнгөрсөн оноос аймгийг нийтэд нь буюу 14 сумыг хамруулан хэрэгжүүлж байна. Тус төсөл бол яг хөдөөгийн иргэдийн амьдрал ахуй, тулгарч буй бэрхшээл, тулгамдаж, дутагдаж буй зүйл дээр тулгуурлан хэрэгцээтэй хөрөнгө оруулалтыг хийж, бас аж ахуйгаа урт амжилттай авч явах чадварыг суулгаж өгч буй үнэ цэнэтэй, үр дүнтэй төсөл. Өөрөөр хэлбэл энэ төсөл хэрэгжсэнээр хөдөө орон

нутгийн хөрс сууринд хөгжлийн маш том тулгуур баганыг босгож чадлаа гэж миний хувьд дүгнэж байгаа. Мал аж ахуйн салбарын олон тулгамдсан асуудлыг малчдын эрэлт хэрэгцээн дээр үндэслэн шийдэж өглөө шүү дээ.

**-Харин малчид гэлтгүй төслийн үр шимийг хүртсэн олон хүн ам сайтай байх шиг байна...**

Яг цаг үе ээ олсон, оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлж чадаж байгаа учраас их сайн үр дүн гарж байна л даа. Төслөөс эхлээд ямар асуудал тулгамдаж байгааг асууж, судалдаг. Үүнийхээ дагуу шаардлагатай хөрөнгө оруулалтыг маш чанартай хийдэг. Түүний үр дүнд урт удаан жил ашиглах, үр өгөөжөө өгөх бүтээн байгуулалтууд хийгдэж чаддаг. Мал аж ахуйн салбарт бол маш их хөрөнгө оруулалтыг хийсэн. Тухайлбал төсөл хэрэгжиж буй 3 суманд 20 сая төгрөгийн өвс, тэжээлийн хөнгөлөлттэй тусламж үзүүлснээс гадна инженерийн хийцтэй гүн өрмийн 19 худаг, мал угаалгын 17 ванн, өвс, тэжээлийн 10 агуулахыг төслөөс барьж өгсөн. Мөн бүх сумдыг өвс, тэжээлийн агуулах саравчтай болгохоор төлөвлөснөөс одоогийн байдлаар 10 суманд бариад байна. Түүнчлэн бэлчээр усжуулалт, хөдөөгийн хүн ам болон малын ундны худаг ус гаргахад чамгүй их хөрөнгө зарцуулж, төсөл хэрэгжиж буй 3 суманд малчдын мэдээллийн төвийг тохижуулж өгсөн. Тал хээр зонхилсон бүс нутагтай манай аймгийн хувьд малчид үхэр, малаа ихэвчлэн хээрээр байлдадаг учир мал зэрлэгшиж, малын эмч нар шүлхий болон бусад өвчний вакцин хийхээр гэмтэж, бэртэж, малд дайруулах цаашлаад амь насанд ч аюул тулгардаг. Харин төслөөс 70 хувь, сум тус бүр 30 хувийн санхүүжилтийг гарган энэ онд бүх суманд малын үзлэг тарилгын зогсоолыг хийж ашиглалтад оруулаад байна. Мал аж ахуйн мэргэжилтнүүд маань сэтгэгдэл маш өндөр байгаа. Төслийн шугамаар аймгийн хэмжээнд 686 өрх бүхий 20 бэлчээр ашиглагч малчдын бүлэг байгуулагдан бэлчээрээ менежменттэй ашиглан, мал аж ахуйгаа хамтран төлөвлөөд, хөдөлмөрөө хоршоод амжилттай ажиллаж, амьдарч явна. Малчид бүлгийн зохион



байгуулалтад орсноор зөвхөн бэлчээр, малын гаралтай түүхий эд боловсруулах гэлтгүй малынхаа чанарыг сайжруулж, эрсдэлтэй үед ашиглах зориулалттай “Дундын сан” бий болгож зарим санхүүгийн асуудлуудаа хамтраад шийдээд явж байна.

**-Төсөл хэрэгжсэний үр дүнд цөөнгүй иргэдийн амьдрал ахуй сайжирч, жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг иргэдийн ашиг орлого өссөн үзүүлэлт гарсан байна лээ...**

Сумын төвд амьдардаг амьдралын түвшин тааруу, мөн тэтгэвэрт гарсан, мэргэжил, боловсролгүй, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгааны улмаас ажил олддоггүй, өрхийн үйлдвэрлэлээ өргөжүүлэх хүсэлтэй ч ажлын байр, санхүүгийн боломжгүй олон хүн энэ төслийн буянаар ажилтай, орлоготой болж, амьдрал ахуй нь өсөн дээшилж сайн сайхан амьдарч байна. Мөн олон ч бичил бизнес эрхлэгчдийг төрөл бүрээр дэмжиж, сургалт хийлгэж туршлага судлуулж чадваржуулсан даа. Тухайлбал өнгөрсөн жил манай аймгаас хоёр ч жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийг төслөөс зардлыг нь 100 хувь дааж, ӨМӨЗО-ны Шилийн гол аймагт болсон үзэсгэлэн худалдаанд оролцуулан туршлага судлуулж, 10 гаруй сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн борлуулаад ирсэн байх жишээтэй. Төслийн шугамаар нийт 133 хүн ажлын байраар хангагдсаны 9 нь өрх толгойлсон эмэгтэй бол 8 нь хөгжлийн бэрхшээлтэй бүсгүйчүүд байгаа юм. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа манай аймагт 2018 онд эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл нийт 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгөө оруулалт хийгээд байна.



СУХБААТАР АЙМАГТ

# 2.3 ТЭРБУМ ГАРУЙ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТ

ХИЙГДСЭНИЙ 90 ГАРУЙ ХУВЬ НЬ МАЛ  
АЖ АХУЙН САЛБАРТ ЗОРИУЛАГДЖЭЭ

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Түвшинширээ сумдад хэрэгжиж, 2020 оноос бүх суманд хүрч ажиллаж байгаа билээ. Төсөл хэрэгжсэнээс хойш өнөөдрийг хүртэл 2.3 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, 517 хүн төслийн үр шимийг шууд хүртээд байгаа юм.



Төслийн хүрээнд бэлчээр ашиглагч малчдын 20 бүлэг байгуулагдаж, бэлчээрийн менежментийн 3 жилийн төлөвлөгөө боловсруулан орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулж, хил заагаа тодорхойлон газрын LM системд бүртгүүлэн, бэлчээрээ чөлөөлөн ажиллаж байна. Үүний үр дүнд 890 га бэлчээрийн талбайг малын хөлөөс чөлөөлжээ.



Тал, хээр нутгийн мал, малчдад хамгийн их дутагддаг инженерийн хийцтэй, гүн өрмийн худгийг төслийн 432 сая төгрөгийн санхүүжилтээр 19-ийг шинээр барьж ашиглалтад оруулсанаар 32.000 га бэлчээрийн усан хангамж сайжирч, 159 өрх, 95.600 гаруй толгой мал ундны усаар хангагдсан байна.



ЗЗБУХТ-ийн санхүүжилтээр 9 малчны хоршоонд 810 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг Жижиг дунд үйлдвэрийн газраар дамжуулж олгосон. Тус зээлд Сүхбаатар аймгаас “Ашид мөнх баян” хоршоо 114 сая, “Мөнгөн саам” хоршоо 60 сая төгрөгийн зээлд хамрагдаж, тус хоёр хоршооны 710 гишүүн шууд ашгийг нь хүртэж байгаа аж.



“ХААН БАНК”-аар олгогдож буй төслийн хөнгөлөлттэй зээлд хөдөө аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг нийт 8 аж ахуй нэгж 449.500.000 төгрөгийн зээл авч, 3 аж ахуй нэгж нь төслийн батлан даалттай зээлд хамрагджээ.

Социализмын үеэс хойш ашиглагдаагүй байсан бог мал угаалгын ванныг төслийн шугамаар нийт 17 ширхэгийг 240 сая төгрөгөөр барьж байгуулснаар 654 өрхийн 506,866 мал сүргийг паразит буюу шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэв.

Эмэгтэйчүүд давамгайлсан 32 бүлэг төслийн хүрээнд байгуулагдаж, 20 гаруй удаагийн сургалтад хамрагдан чадваржиж, өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй цөөнгүй иргэд ажилтай, орлоготой болжээ. Түүнчлэн төслийн 30 сая төгрөгийн санхүүжилтээр 3 ажлын байрыг засварласнаар олон үйлдвэрлэл эрхлэгчид үйлдвэрлэл, үйлчилгээгээ явуулж, аж ахуйн нэгжүүд бараа бүтээгдэхүүнээ иргэдэд ойрхон, тав тухтай орчинд борлуулах боломжтой болсон юм. Төсөл хэрэгжсэний үр дүнд нийт 133 хүн ажлын байраар хангагдсан байна.



Төслийн хөрөнгө оруулалтаар малчдад нэн шаардлагатай өвс, тэжээлийн агуулах саравчийг 990 сая төгрөгөөр 9-ийг шинээр барьснаас гадна 87 сая төгрөгөөр засварын ажил хийгджээ. Түүнчлэн 14 сая төгрөгийн үнэ бүхий 18 ширхэг оготно устгах хэрэгслийг малчны бүлгүүдэд шийдэж өгснөөр 18.000 га талбайд устгалын ажил хийгдэж, бэлчээр сэргэсэн үр дүн гарчээ.



Гурван суманд 29 сая төгрөгөөр малчдын сургалт мэдээллийн төвийг төслөөс тохижуулж өгснөөс гадна мал эмнэлгийн үйлчилгээний 13 зогсоолыг 65 сая төгрөгөөр барьж байгуулснаар мал эмнэлгийн ажилтнууд аюулгүй орчинд ажил, үйлчилгээгээ явуулах нөхцөлийг бүрдүүлжээ.

## БАРУУН-УРТ СУМЫН “АРГА ТҮШИГ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ О.ДҮҮРЭНБИЛЭГ:



Манайх махны чиглэлийн хагас эрчимжсэн үхрийн фермерийн аж ахуй эрхэлдэг. ЗЗБУХТ-ийн батлан даалттай зээлд 2020 онд хамрагдаж 70 сая төгрөгийн зээл авсан. Зээл авсны үр дүнд үхрийн байр барьж, хадлан, тэжээлээ бэлдэж, эцэг малаа сайжруулж аж ахуйгаа өргөжүүлж байна. Төслийн шугамаар зохион байгуулсан төсөл бичих удаа, дараагийн сургалтад суусны үр дүнд амжилттай сайн бичиж зээлд хамрагдсандаа их баяртай байгаа.



## ЭРДЭНЭЦАГААН СУМЫН “БАЯН-УНДАРГА” ЭДБ-ИЙН ГИШҮҮН Л.ЭРДЭНЭЦЭГ:

Манай бүлэг 2018 оны сүүлчээр төслийн хүрээнд байгуулагдсан. Бүлгийн зохион байгуулалтад орчихоор бүгдээрээ хамтраад ажлаа хийхээр ажлын бүтээмж их сайн байдаг юм байна. Бид наймуулаа арьс илдэх, оёдол хийх, хүнсний ногоо тариалах, цагаа идээ боловсруулах, суран эдлэл зэрэг төрөл бүрийн өрхийн аж ахуй эрхэлдэг. Төслөөс биднийг маш гоё тав тухтай ажлын байраар хангаж өгснөөс гадна төрөл бүрийн сургалтуудыг явуулж, гурван ч гишүүнд маань батлан даалттай зээл гаргаж өгсөн. Миний хувьд 10 сая төгрөг аваад хүлэмжийн аж ахуй байгуулж, нэг тонн усны савтай болсон.



## ЭРДЭНЭЦАГААН СУМЫН “ДАЛАЙ БУЛАГ” БАМБ-ИЙН АХЛАГЧ М.НАРАНЦОГТ:



Анх бүлгээ байгуулахад 10 өрх л байсан, одоо 40 өрхийн 20 мянга гаруй мал бий. Төслийн сургалтуудад сууж гурван жилийн төлөвлөгөө гаргаад газрын нэгдсэн системд бүртгүүлж, бэлчээрээ өнжөөж, чөлөөлж сурсан. Манай бүлэг сумынхаа 9 бүлгийн хооронд явуулсан бэлчээр чөлөөлөх уралдаанд түрүүлсэн, нэлээд идэвхтэй ажилладаг бүлэг л дээ. Тэр зүтгэлийг маань төслөөс үнэлж гүн өрмийн худаг гаргаж өгч, булаг хаших зардлыг мөн шийдэж өгсөн байгаа. Малчдад хамгийн хэрэгтэй хөрөнгө оруулалтыг хийж чаддаг маш үр дүнтэй төсөл дөө.





### БАЯНДЭЛГЭР СУМЫН “УРТЫН НУРУУ” БАМБ-ИЙН АХЛАГЧ Б.ДАВААЖАРГАЛ:

Анх төслийн хүрээнд 25 айлын 20 мянган малтай бүлгээ байгуулж байлаа. Одоо 184 гишүүн бүхий 33 өрхийн 25,000 толгой малтай, 48,097 га талбайтай болсон. Бүлгээрээ ажилласны давуу тал нь айл саахалтаараа нийлж мал ахуйгаа авч явахаас гадна гар худаг гаргах, булаг хаших, хашаа хороо барих зэрэг бүтээн байгуулалтын ажлыг хамтран хийж, бэлчээрээ төлөвлөгөөтэй ашиглаж, цаг хүндэрсэн үед ашиглах зориулалттай “Дундын сан”-г бүрдүүлэн ажиллаж байна. Төслөөс 3 гар худаг засварлах зардлыг шийдэж өгснөөс гадна олон үр дүнтэй сургалтуудыг зохион байгуулсан.



### БАЯНДЭЛГЭР СУМЫН “УНДРАХ” ЭМЭГТЭЙЧҮҮД ДАВМГАЙЛСАН БҮЛГИЙН АХЛАГЧ Ж.СУГАРЖАВ:

Төсөл манай суманд анх 2018 онд хэрэгжиж эхлэхэд бүлгээ байгуулсан. Бүхий л төрлийн сургалтуудад нь сууж их зүйл сурч авсан даа. Бид нар шиг өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг хүмүүст зээл олдоггүй юм. Харин төслийнхөө буянаар өнгөрсөн жил 5 сая төгрөгийн зээл авч оёдлын хөл машин авсан. Энэ жил зээлээ төлж дуусаад 10 сая төгрөгийн зээл авч материал түүхий эдээ татаж, бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг нэмэгдүүлэхийн хэрээр борлуулалт, худалдан авалт нэмэгдэж байна.




### ТҮВШИНШИРЭЭ СУМЫН ИРГЭН, ГАЗАР ТАРИАЛАНГИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ Ж.АЛТАНЦЭЦЭГ:

Төслөөс зохион байгуулсан хүнсний ногоо тариалалт, хүлэмжийн аж ахуй эрхлэх, цагаан идээ боловсруулах, төсөл бичих, бүлэг байгуулах зэрэг олон төрлийн сургалтуудад сууж их зүйл сурч авсан. Одоо батлан даалттай зээлд хамрагдах гээд төслөө бичиж байна. Бичил бизнес эрхэлдэг олон хүмүүсийг дэмжиж буй төслийнхөө хамт олонд талархсанаа илэрхийлье. Манай сумаас гэхэд 10 гаруй хүн зээл аваад үйлдвэрлэл үйлчилгээгээ өргөтгөд явж байгаа.



### ТҮВШИНШИРЭЭ СУМЫН “ЖАРГАЛАНТ” БАМБ-ИЙН АХЛАГЧ Д.БАТТУЛГА:

ЗЗБУХТ анх манай суманд 2018 онд хэрэгжиж эхлэхэд 30 өрхийн 15 мянган толгой малтай бүлгээ байгуулж байлаа. Одоо 50 гаруй өрхийн 21 мянган толгой малтай болсон. Малчид бүгдээрээ хамтарч хөдөлмөрлөж, бэлчээрээ төлөвлөгөөтэй ашиглаж, өнжөөдөг болсон нь бүлэг болсны үр дүн юм. Төслөөс бидэнд хамгийн их дутагдаж байсан гүм өрмийн худаг гаргаж өгч, 2 худаг засварлах зардлыг шийдэж, бас мал угаалгын ванн барьж өгсөн. Өмнө нь бид 10 километр малаа тууж очиж угаалгадаг байлаа.



Хэнтий аймгийн ХХААГ-ын дарга Ж.ЭНХ-АМГАЛАН:

## МАЛЧДАД ЗОРИУЛСАН ХАМГИЙН ӨНДӨР ДҮНТЭЙ, ҮР ӨГӨӨЖТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛ ЗЗБУХТ-ИЙН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ



“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл хэрэгжиж буй зургаан аймгийн нэг нь Хэнтий. Төслийн хэрэгжилт, үр дүн, өгөөжийн талаар аймгийн Хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Энх-Амгалантай ярилцлаа.



**-ЗЗБУХТ төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааны үр дүн танай аймагт хэр гарч байна вэ?**

Үр дүн маш сайн гарч, цаашид он удаан жил ашиглагдах томоохон бүтээн байгуулалтын ажлууд энэ төслийн буянаар манай аймагт хийгдэж байна. Төсөл анх 2018 оны сүүлчээр хэрэгжиж эхэлсэн. Одоогоор төсөлд 3000 орчим хүн хамрагдаж үр шимийг нь хүртээд байна. Хоёр жил гаруйн хугацаанд 2.6 тэрбум гаруй төгрөгийн санхүүжилтийг хийгээд байгаа. Улсаас хийгдэж байгаагүй олон бүтээн байгуулалтын ажлууд төслийн үр дүнд ар, араасаа хийгдэж, ялангуяа мал аж ахуйн салбарт яг малчдад тулгамддаг, хэрэгцээ шаардлагатай худаг, бог мал угаалгын ванн, өвс, гэжээлийн агуулах саравч барьж өгснөөс гадна түймэр унтраах мотор, оготно устгах төхөөрөмж, мотоцикл зэргийг шийдэж өгсөн. Өмнө нь улсын төсвөөр аймгийн хэмжээнд жилд 4-5

худаг л гаргадаг байсан бол төслийн хүрээнд хоёрхон жилийн хугацаанд 18 сум, 5 тосгонд 31 гүн өрмийн орчин үеийн хийцтэй худгийг гаргаж өгсөн байх жишээтэй. Худаг гаргах ажил нь дан ганц хүний болон айл өрхийн бус бүтэн нэг бүлгийн, цаашлаад нийт сум орон нутгийн малчдын амьжиргаанд чухал нөлөө үзүүлэхүйц ажил байдаг л даа. Ер нь аймгийн түүхэнд малчдад зориулсан хамгийн өндөр дүнтэй, үр өгөөжтэй үйл ажиллагаа бол ЗЗБУХТ-ийн нэмэлт санхүүжилт юм.

**-Харин яг хэрэгцээтэй газар нутагт нь шаардлагатай хөрөнгө оруулалтыг оновчтой хийж чадаж байгаа учраас төслийн үр дүн их сайн гарч байх шиг байна...**

Тийм ээ. Өөрийн тань хэлдгээр яг дутагдалтай зүйлийг нь шаардлагатай газар нь барьж байгуулахаар ядаж цаашдаа удаан хугацаанд ашиглаад оршин тогтноод явах үнэ цэнтэй ажил болж чадаж байгаа юм. Зөвхөн бүтээн байгуулалт гэлтгүй малчны, эмэгтэйчүүдийн бүлэг, бичил бизнес эрхлэгчдэд олон удаагийн сургалт хийсний үр дүнд хүмүүс тус, тусын аж ахуй, бизнесээ амжилттай, тогтвортой авч явах чадварт суралцаж, ахиц дэвшил маш хурдан гарч байна. Тухайлбал гүн өрмийн худгийг бэлчээрийн усан хангамж муутай говь, хээр тал газар гаргаж, гэртээ үйлдвэрлэл явуулдаг бүлгийн гишүүдэд ажлын байрыг засварлаж өгч, бичил бизнес эрхлэгчдэд урт хугацаатай, хүү багатай, батлан даалттай зээлд хамруулж дэмжсэн байх жишээтэй.

**-Хэнтий аймаг Улсын аварга малчдынхаа тоогоор олон жил улсад тэргүүлж буй, 4.6 сая малтай, 11.5 мянган малчинтай өнөр аймаг. Тэр ч утгаараа мал аж ахуйн салбарт бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн дутагдал, бэлчээрийн даацын асуудал нэлээд хурцаар тавигддаг. ЗЗБУХТ хэрэгжсэнээр бас багагүй асуудлыг шийдэж өгсөн болов уу?**

Яг л өөрийн тань сая хэлсэн

асуудлуудыг төслөөс шийдэж өгч байгаа. Нэг давуу тал нь манайх олон малчинтай учир цөөнгүй малчны бүлгүүд өмнө нь байгуулагдсан байсан. Тэр суурин дээрээ сургалтаа хийгээд, нэмж бүлгүүдээ байгуулаад явсан нь үр дүн гарч, бэлчээр чөлөөлөлт, сэргээлтийн ажил сайн хийгдэж, бүлэг бүр бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, менежменттэй болсон. Төслөөс малчдын бүлгүүдтэйгээ хаана, ямар зүйл дутагдалтай байна вэ, гэдгээ хамтран ярилцан шийдвэрлээд явсан нь ЗЗБУХТ-ийн хамгийн гол онцлог, үр дүн юм. Бас төслөөс нийт хөрөнгө оруулалтын 70%-ийг, үлдсэн 30%-ийг нь тухайн орон нутгаас гаргуулсан нь тал, талын хариуцлагыг сайжруулж, орон нутгийн оролцоог нэмэгдүүлсэн. Үүнд бас малчдын оролцоог ч давхар хангуулж, худаг, ванн, тоног төхөөрөмжүүдээ ариг гамтай ашиглах, удаан хугацаанд хэрэглэх суурийг тавьж өгсөн. Мөн цаашид энэ ажлыг үргэлжлүүлэн хийх санаа сэдлийг ч давхар өгч байгаа юм.

**-Төсөл хэрэгжсэнээр өөр ямар үр дүн гарсан бэ?**

Малчдын бүлгүүд маань түрүүчээсээ хоршоо болж байна. Энэ нь төрөөс хоршоологчдыг дэмжих бодлогод нэлээд сайн суурь бэлтгэл ажил болж гэж миний хувьд үзэж байгаа. Мөн эмэгтэйчүүд давамгайлсан бүлгийнхэн маань ч олон удаагийн сургалтад суусны үр дүнд хоршоо болох, аж ахуй нэгж байгуулах, аймаг, орон нутгийн хэрэгцээний чамгүй хувийг хангадаг үйлдвэрлэл эрхлэгчид болж өсөж, дэвшиж байна. Энэ бол төсөл хэрэгжсэний хамгийн гол үр дүн юм. Хөдөө аж ахуйн салбарт ажилладаг мэргэжилтнүүд болон малчдын хандлага ч удаа дараагийн сургалтад сууснаар өөрчлөгдсөн. Үүнийгээ дагаад аж ахуй, үйлдвэрлэлээ бие даан амжилттай авч явж, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүтээмж эрс нэмэгдсэн үзүүлэлт гарч байна.



ХЭНТИЙ АЙМАГТ

# 2.6 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ХИЙГДЭЖ, 2881 ХҮН ТӨСЛИЙН ҮР ШИМИЙГ ХҮРТЖЭЭ


ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагаа Хэнтий аймагт 2018 оноос эхлэн хэрэгжиж, өнөөдрийг хүртэлх хугацаанд 2.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, 2881 хүн төсөлд хамрагдан чадваржиж, амьдрал ахуйгаа дээшлүүлж, ашиг орлогоо өсгөж явна.



Байгаль цаг уур, уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, нөхцөл байдлыг даван туулах чадвар суулгах, бэлчээрийн менежментийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд төслийн шугамаар 23 бүлэг байгуулагджээ. Эдгээр бүлгүүдэд 393,861 толгой мал бүхий 745 гаруй малчин өрх, 232.861 га бэлчээрийн талбайг ашиглаж байна.



Шүлхий өвчин, малын гачиг ихтэй тус аймагт төслийн 525 сая төгрөгийн санхүүжилтээр 35 ширхэг мал ванний барьж, байгуулсан байна. Үүний үр дүнд нийт малынхаа 80-90%-ийг угаалгад хамруулснаар малын гоц халдварт өвчний гаралт эрс буурсан үзүүлэлт гарчээ.



Төслийн хүрээнд Хэрлэн, Өмнөдэлгэр, Батширээт, Норовлин сумдад нийт 224 гишүүн бүхий 30 эмэгтэйчүүд давамгайлсан бүлэг байгуулагдаж, 10 гаруй удаагийн төрөл бүрийн сургалтад хамрагдсан байна. Бүлгийн гишүүд төслийн 545 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж, засварлагдсан 8 ажлын байранд түрээсийн дарамтгүйгээр үйлдвэрлэл үйлчилгээгээ явуулж, бараа бүтээгдэхүүнээ борлуулж буй. Үүний үр дүнд 9 иргэн ажлын байраар хангагдаад байгаа юм.



ЗЗБУХТ-ийн зорилтод Норовлин, Өмнөдэлгэр, Батширээт сумдад 7.5 сая төгрөгөөр тус бүр нэг мотоциклыг төслийн зохицуулагч нарт шийдэж өгснөөр төлөвлөгөөт үйл ажиллагааг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэх нөхцөл боломжоор хангав. Түүнчлэн 45 сая төгрөгөөр 3 малчдын сургалт мэдээллийн танхимыг тохижуулж өгснөөс гадна 495 сая төгрөгөөр 4 өвс, тэжээлийн агуулах саравчийг шинээр барьж, 1 агуулахыг засварлажээ.



Хүнсний ногоочдод нэн шаардлагатай зорь, агуулахыг төслийн 130 сая төгрөгийн санхүүжилтээр барьж өгснөөс гадна 36 сая төгрөгийн үнэ бүхий 18 ширхэг мал эмнэлгийн үйлчилгээний тоног төхөөрөмжийг сумдад нийлүүлж, малын эмч нарын аюулгүй байдлыг хангав. Түүнчлэн малчны бүлгүүдэд гал унтраах мотор, оготно устгалын төхөөрөмж, иж бүрдлийг шийдэж өгснөөр 15000 га талбайд устгал хийгдэн бэлчээр сэргэж, галын аюулаас малчдын эд хөрөнгийг галын аюулаас хамгаалж байна.



Тал хээр, говийн сумын малчдад хамгийн их тулгамддаг худаг усны асуудлыг төслөөс шийдэж, 713 сая төгрөгөөр 31 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаснаар бэлчээрийн усан хангамжийг 3 дахин нэмэгдүүлж, олон мянган хүн, малыг ундны усаар хангаж байна.



### ХЭРЛЭН СУМЫН “ЦОГТ ӨНДӨР” БҮЛГИЙН АХЛАГЧ Х.ГАНЗОРИГ:

Миний хувьд ногоон тэжээлийн ургамал тариалах зорилгоор ЗЗБУХТ-ийн батлан даалттай зээлд хамрагдаж, 150 сая төгрөгийн зээл авсан. Зээлд хамрагдахад олон бичиг, цаас гэж явдал чирэгдэл болоод байхгүй, төсөл бичих сургалтаа явуулчихдаг ёстой амар юм билээ. Удахгүй ургацаа авч, зээл авсныхаа үр шимийг үзнэ дээ. Мэдээж чамгүй өндөр дүнтэй зээл авсны үр ашиг нь өндөр л гарна гэж бодож байгаа.



### НОРОВЛИН СУМЫН АНГИРТ БАГИЙН ЗАСАГ ДАРГА Д.ШИЖИРМӨНХ:

Ангирт багт ЗЗБУХТ 2018 оноос хэрэгжиж, 2019 оноос төсөлтэй хамтран ажиллаж, бэлчээр чөлөөлөх хил заагийг баталж, хэрэгжүүлэн 45 мянган га талбайг чөлөөлсөн. Бид өмнө нь нэг бэлчээртээ өвөл, зунгүй амьдарч, малаа бэлчээсний улмаас бэлчээр талхалдаад улаан халцгай болж, 6 сар гэхэд өвс ч ургадаггүй байлаа. Харин чөлөөлсний үр дүнд одоо бэлчээр бүрэн сэргэсэн. Бидний бэлчээрээ өнжөөж, амраасан арга туршлагыг манай сумын болон зэргэлдээ сумын малчид ирж судалдаг. Төслөөс манай багийн хэмжээнд мал угаалгын ванн, инженерийн хийцтэй 2 худаг гаргаж өгсөн. Мөн малчдын өөрсдийн хөрөнгөөр 6 худаг гаргаснаар усгүйгээс болоод ашиглах боломжгүй байсан бэлчээрийг ашиглах боломжтой болсон. Цаашид ЗЗБУХ төсөл маань эх орны дэмжлэг, туслалцаа хэрэгтэй олон газарт хүрч бэлчээр сэргээх ажлыг хийгээсэй гэж хүсэж байна.



### ӨМНӨДЭЛГЭР СУМЫН “ТАРГИЛЖИЙН ГОЛ” БАМБ-ИЙН АХЛАГЧ Ц.БАТСҮХ:

Өмнө нь бид 8 өрх бүхий нөхөрлөл байсан юм. Харин 2019 онд ЗЗБУХТ манай суманд хэрэгжих болсноор бүлэг болж, одоо 24 өрхийн 17,740 толгой мал байна. Бүлэг болж, гишүүд олон болсноор бэлчээр хамгаалах, оготно устгах, худаг ус гаргах зэрэг олны хүч шаардсан ажлыг бүгдээрээ хамтраад хийчихдэг давуу талтай. Манай сум үлийн цагаан оготно маш ихтэй. Төслөөс устгах төхөөрөмжийг тавьж өгснөөр одоо бараг оготногүй болсон. Бас мал угаалгын ванн, гүн өрмийн худаг гээд малчин бидний олон жил бодож явсан, их хөрөнгө мөнгө шаардсан ажлуудыг хийж өгсөнд их баярлаж явдаг.



### БАТШИРЭЭТ СУМЫН “БИНДЭРЪЯ СҮҮ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ Г.ГАЛСАН:

ЗЗБУХТ хэрэгжиж, сургалтууд явагдаж эхлэх үеэс тасралтгүй сууж, аж ахуйгаа тогтвортой, амжилттай авч явах, бизнес төсөл бичих сургалтуудад хамрагдаж, өнгөрсөн жил төсөл бичээд 50 сая төгрөгийн зээл авсан. Манайх сүүний үйлдвэрлэл явуулдаг. Авсан зээлээрээ үйлдвэртээ 2 тоног төхөөрөмж, хүргэлт, ачилтын 1 машин авч, ажлын байр барьсан. Бас 8 ажилтантай байсан бол одоо 13 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна даа.







### ХЭРЛЭН СУМЫН “ЭВИЙН ХҮЧ” ЭДБ-ИЙН ГИШҮҮН Н.ЦЭЦЭГСАЙХАН:

Манай бүлэг төслийн шугамаар 2019 онд байгуулагдсан. Бүгд л сургалтад хамрагдаж, тус, тусын үйлдвэрлэл, үйлчилгээг явуулаад явж байгаа. Миний хувьд бөөрөнхий мах, котлетны мах, бууз, банш зэрэг бэлэн бүтээгдэхүүний цех ажиллуулдаг. Төслийн хөнгөлөлттэй зээлд 2020 онд хамрагдаж, 5 сая төгрөгийн зээл авч тоног төхөөрөмжөө өөрийн болгон авч, төлж дуусгаад энэ жил дахиад 5 төгрөгийн зээл авч үйлдвэрлэлээ өргөтгөсөн дөө сэтгэл их өндөр байгаа.



### НОРОВЛИН СУМЫН “БАЯН СУУ” ЭМЭГТЭЙЧҮҮД ДАВМГАЙЛСАН БҮЛГИЙН АХЛАГЧ Б.НАМЖИЛМАА:

Манай бүлэг 2019 онд төслийн хүрээнд анх 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Бид цагаан идээ боловсруулж, борлуулдаг. Төслөөс зохион байгуулсан бүхий л сургалтуудад сууж, туршлага судлах уулзалтуудад тасралтгүй оролцож их зүйл сурч авсан даа. Нэг гишүүн маань төслийн эргэлтийн хөрөнгийн 5 сая төгрөгийн зээлд хамрагдаж, сүү цагаан идээ боловсруулах саваа шинэчилсэн.



### ӨМНӨДЭЛГЭР СУМЫН “БИЛЭГ” ЭМЭГТЭЙЧҮҮД ДАВАМГАЙЛСАН БҮЛГИЙН АХЛАГЧ Н.ЖАВ:

Бид гэр бүлийнхээ хүрээнд гурилан бүтээгдэхүүний цех ажиллуулдаг байж байгаад төслийн хүрээнд 2019 онд бүлгийн зохион байгуулалтад орж, олон удаагийн сургалтад сууж их зүйл сурч авсан. Анх бид чинь бичиг цаас боловсруулах ч ойлголтгүй байсан хүмүүс сургалтад суусны үр дүнд бизнес төсөл бичих хэмжээнд хүртэл очсон шүү дээ. Бизнес төсөл бичээд төслийн батлан даалттай зээлд хамрагдаж, 10 сая төгрөгийн зээл авч, тоног төхөөрөмжөө сайжруулсан. Төслийн санхүүжилтээр ажлын байр засварлаж өгсөн байгаа. Удахгүй байрандаа орно доо. Орчихвол түрээс төлөхгүй үйлдвэрлэл үйлчилгээгээ явуулна.



### БАТШИРЭЭТ СУМЫН “НАВЧИТ ХАЙРХАН” БАМБ-ИЙН АХЛАГЧ Ц.НАСАНЖАРГАЛ:

Өмнө нь манай бүлэг ой хамгаалах нөхөрлөлдтэй хамтран ажилладаг байж байгаад 2019 онд төсөл хэрэгжихэд БАМБ болж нэгдэн бэлчээрийн менежментийн 3 жилийн төлөвлөгөө боловсруулан орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулж, хил заагаа тодорхойлон газрын LM системд бүртгүүлэн, бэлчээрээ сэлгэж, чөлөөлөн ажиллаж байна. Манай бүлэг одоо 42 өрхийн 148 гишүүнтэй, 36,2 мянган толгой малтай. Төслөөс манай бүлэгт мал угаалгын ванн, жил дараалан 2 гүн өрмийн худаг гаргаж, түймрийн үлээгч мотороор хангасан нь социализмаас хойш бидэнд дутагдаж, тулгамдаж байсан нэн чухал асуудлуудыг шийдэж өгсөнд маш их баяртай байна.



# ЗУРГААН АЙМГИЙН 9 ХОРШООДОД 30-126 СЯ ТӨГРӨГИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОЛОО

ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” Нэмэлт санхүүжилт төслөөс Говь-Алтай, Булган, Хөвсгөл, Сүхбаатар, Дорнод зэрэг зургаан аймгийн 9 хоршоодод 30-126 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээг зохион байгууллаа. Тус дэмжлэгийг олгосноор хөдөө аж ахуй тэр дундаа мал аж ахуйн үйлдвэрлэл, малын гаралтай түүхий эдийн боловсруулалт, борлуулалт сайжирч, хоршооны гишүүн 1000 гаруй хүний амьдралд томоохон дэмжлэг, тус болж байгааг зээлд хамрагдсан хоршооны төлөөллүүд хэлж байлаа.



## Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан:

“Монгол Улс бол тархай бутархай, өргөн уудам газар нутагтай, мал аж ахуйн орон. Энэ утгаараа орон нутгийн хөгжилд хамгийн чухал үүрэг гүйцэтгэх бүтэц нь хоршоо юм. Үйлдвэрлэл эрхлэгчид, тэр дундаа малчид маань хоршиж ажиллаж байж амжилтад хүрнэ. Тиймээс төрөөс хоршоодыг дэмжих бодлого барьж, ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” Нэмэлт санхүүжилт төслөөс 6 аймгийн 9 хоршоонд нийт 810 сая төгрөгийн 5 жилийн хугацаатай, эхний жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, жилийн 5 хувийн хүүтэй зээлийг манай Жижиг, дунд үйлдвэрийн газраар дамжуулан олгоод байна. Энэ нь орон нутгийн хөгжилд томоохон хувь нэмрээ оруулахуйц хөрөнгө оруулалт боллоо.”



## Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны дэд Ерөнхийлөгч Ц.Алтантуяа:

“Өнгөрсөн 6 дугаар сард “Хоршооны тухай хууль”-ийг баталсан. Хуулиар жижиг, дунд үйлдвэр, хоршоогоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “Сум хөгжүүлэх сан”-г “Хоршоог хөгжүүлэх сан” болгон өөрчилж хоршоодод хөнгөлөлттэй зээл олгох боломжийг бүрдүүлсэн. Энэ хүрээнд хоршоодод хөнгөлөлттэй зээл олгох, хоршооны тухай хуулийг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулж, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөс 11 хоршоонд хөнгөлөлттэй зээл олгохоос эхний ээлжид 9 хоршоонд 30-126 сая төгрөгийн зээл олголоо. Мэдээж есөн хоршооны цаана есөн сумын 1000 гаруй ард иргэдийн амьдрал сайжирч, ажлын байр нэмэгдэж, ашиг орлого нь өсөж байгаад их баяртай байна.”



## “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн зохицуулагч С.Занданбал:

“Манай төсөл НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилтээр хэрэгждэг. 2018 оноос Нэмэлт санхүүжилтийн төслөө эхлүүлж, одоо 6 аймгийн 24 суманд үйл ажиллагаа явуулж байгаа. Өнгөрсөн оноос хөрөнгө оруулалтын хэмжээгээ нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлж, хамрах хүрээгээ тэлж, Архангай, Өвөрхангай, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод гэсэн 6 аймгийн нийт 98 суманд хэрэгжүүлж байна. Бэлчээрийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, зах зээлийн хөгжил гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Бэлчээрийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бүрэлдэхүүн хэсгийнхээ хүрээнд малчдын бүлэг байгуулан бэлчээр ашиглах гэрээг сумын ИТХ-аар батлуулж, бэлчээрийн менежментийн гурван жилийн төлөвлөгөө гарган ажиллаж байгаа. Харин сумдын түвшинд гүн өрмийн худаг гаргах, мал угаалгын ванн, өвс тэжээлийн агуулах, ажлын байр барих зэрэг бүтээн байгуулалтад нийт 8 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийгээд байна. Зах зээлийн хөгжил бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 6 аймгийн 9 хоршоонд 30-126 сая төгрөгийн зээл олгож байгаа юм. Энэ ажил амжилттай хэрэгжвэл бид дараа, дараагийн хөрөнгө оруулалтыг хийгээд явна.”



## ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛД ХАМРАГДСАН ХОРШООДЫН ТӨЛӨӨЛЛИЙН СЭТГЭГДЛЭЭС...



### Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын “Хөвдэлгэр” хоршооны захирал Ч.Мөнхдалай:

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс олгож буй зээлийн хамгийн өндөр дүн буюу 126 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсандаа маш их баяртай байна. Манай хоршоо байгуулагдаад 10 жил болж байгаа, мал аж ахуй, махны чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг. Махны хөргүүртэй машин авах төсөл бичээд шалгарсан. Машинаа ашиглалтад оруулснаар хоршооны маань олон өрхийн орлого, ашиг нэмэгдэж байгаа.”



### Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын “Ашид мөнх баян” хоршооны захирал А.Ганзориг:

“Манайх 2012 онд байгуулагдсан, малын гаралтай түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийж үндэсний үйлдвэрүүдэд нийлүүлдэг. Сумынхаа нийт малчдын 33 хувь буюу 213 өрхтэй малчдын хоршоо. Бид өмнө нь удаа дараа зээлд хамрагдах гэж үзсэн боловч дээд тал нь 15 сая төгрөг л авах боломжтой байсан. Харин “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөс 114 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож буйд маш их баяртай байгаа. Бид өнгөрсөн 2020 оны 4 сараас төслөө бичсэн. Энэхүү зээлээрээ малынхаа чанар, ашиг шимийг сайжруулах, тэр дундаа үхрийн аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөөтэй байна.”



### Дорнод аймгийн Баяндун сумын “Нутгийн хөх чулуу” хоршооны дарга М.Мөнхзориг:

“ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн 50 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, хоршооныхоо үйл ажиллагааг өргөжүүлж, гишүүн малчдынхаа амьдралд бас томоохон хөрөнгө оруулалт оруулж буйдаа баяртай байна. Манай хоршоо 2012 онд байгуулагдсан, 175 гишүүнтэй, малын гаралтай түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх чиглэлээр ажилладаг. Хоршоонд ийм зээл олгож буй нь орон нутгийн иргэдийн амьдралд их том тус дэм болж байна.”

## ХОРШООНЫ ТӨЛӨӨЛӨЛҮҮД ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ АРГА ХЭМЖЭЭ



## БУЛАГ ХАШИХ, ТОХИЖУУЛАХ АРГА



Булаг шандны ундарга багасах, анихад хур бороо, хаврын шар усаар зөөгдсөн хог хаягдал, элс шорооны хуримтлал, илэрц орчмын хөрс малын хөлөөр талхлагдах явдал шууд нөлөөлөхөөс гадна булгийн эхний ус, хөрс хариулгагүй мал, амьтны ялгадсаар бохирдож, халдварт өвчин тархах нөхцөл бүрддэгт анхаарах хэрэгтэй.


### ТЕХНИКИЙН ШИЙДЭЛ:

Булгийн эхийг хашиж хамгаалахад дараах үндсэн шаардлагуудыг бахримтлах нь зүйтэй. Үүнд:

1. Булгийн эх нь малын хөлөөс бүрэн хамгаалагдсан байх
2. Булгийн ундарга, эхийг хөндөж муутгахгүй байх
3. Булгийн ундаргад тулалт үүсгэхгүй байх
4. Төмөр хийц, материал сонгож бат бөх хийх
5. Хүйтний улиралд булгийг ашиглах боломжтой байх

### ХАМГААЛАХ АРГА:

Булгийн эхийг хамгаалах хашааг 24x26 м<sup>2</sup> хэмжээтэй төмөр хийц материалаар нийт 100 метр урттай хийнэ. Булгийн ус цуглуулах талбайн хэмжээнээс хамааран хашааны хэлбэр 4 тал буюу тойрог байж болно. Хашааг 1\*22 см өргөн, хөндлөвчийг 1\*4 см<sup>2</sup> хөндий төмрөөр гагнаж хийнэ. Хашааны өндөр 120 см, шонгийн нийт урт 180 см, шон хоорондын зай 200 см, хашааны сараалж хооронд 15 см, хашааны төмөр шонгийн диаметр 8-10 см-ийн голчтой төмөр трубагаар хийж, дээд талыг битүүлж, зэврэлтээс хамгаалж төмрийн будгаар будна. Шонг 50 см гүнд суулгаж, зэвэнд идэгдэж урвалд орохоос хамгаалан байгалийн чулуугаар чигжиж цементэлнэ. Булгийн урсацын доод талд буюу булгийн хөлд ойролцоогоор 80 см өргөнтэй гадагш онгойдог, явган хаалга хийх нь тохиромжтой.



## УСНЫ НӨӨЦ ХУРИМТЛУУЛАХ АРДЫН АРГА УХААНААС...

Хөв байгуулах, цасны шар усаар өвөлжөө, хаваржаа орчмын бэлчээрийг услах, бордох, цас дарж нөөцлөх, гол, горхиноос гар шуудуу татаж бэлчээр усжуулах, их устай голын усанд өргөх төхөөрөмж тавьж, ногооны талбайг услах, булаг шандны усыг сувгаар татах, зэлүүд бэлчээр эзэмшин ашиглах зэргээр усны нөөцийг хуримтлуулж болно.

### ХУДАГ ГАРГАХ ЗӨВЛӨМЖ

Хөрс ба байгаль орчны нөхцөлөөс хамааран гар худгийг чулуугаар хашсан, модоор хашсан гэсэн үндсэн хоёр хэлбэрт хуваадаг. Говийн бүс нутагт хөрс нь элсэрхэг, нурамтай, модон материалын олдоц муу байдаг зэргээс шалтгаалан ихэвчлэн чулуун хашлагат худаг байгуулдаг уламжлалтай.



- Худаг гаргах ажил эхлэхээс өмнө шаардлагатай материал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж болон чулуу, хайрга зөөж бэлтгэнэ.
- Худгийг хөрсний байдалтай уялдуулан 2.0-3.0 метрээс багагүй голчтойгоор алсаас шатлан ухаж, ус илэрсэн үеэс 1 орчим метр гүн ухаж хангалттай ундаргатай болгоно.
- Ус хүлээн авч нөөцлөх хэсгийг хангалттай зайтай болгохын тулд ус авах хэсэг (цээл)-ийн хашлагыг хүнхэр хийж, чулуугаар хашина. Ингэхдээ хашлага чулууны завсраар дэрс зэргийн ургамлаар жийрэг хийж, чулуунуудыг нурахааргүй өрнө. Энэ жийрэг нь шүүлтүүрийн үүргийг давхар гүйцэтгэнэ.
- Ус хүлээн авах хэсгийн дээд талын хашлагыг хийхдээ чулууг цементэн зуурмагаар гагнаж өрнө. Модоор бас хашиж болно.
- Худгийн амсрын хэсэгт 70 см хүртэл өндөр хүзүүвч хийнэ.
- Худагт гадаргын бохир усыг оруулахгүйн тулд амсрын доод хэсэгт худгийн хашлагын гадна талаар 1 метр хүртэл гүнд шавар манаас хийх шаардлагатай.



# ХӨНӨӨЛТ МЭРЭГЧ АМЬТАДТАЙ ТЭМЦЭХ АРГА



Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтадтай тэмцэх ажилд энгийн механик, биологийн болон микробиологийн аргуудыг хослуулан цаг улирлын байдал, тархалтын

хэмжээнд тохируулан хэрэглэх нь илүү үр дүнтэй. Малчид гэр, өвөлжөө, хаваржаанаас 1-3 километрийн тойрог дотор бэлчээрээ өөрсдөө хамгаалах ёстой байдаг бол 4 буюу түүнээс дээш километр сум, аймаг, улсын хөрөнгө оруулалтаар нэгдсэн зохион байгуулалттайгаар мэрэгч амьтадтай тэмцэх ажлыг зохион байгуулах нь үр дүнтэй юм.

## ЭНГИЙН МЕХАНИК АРГА

Мэрэгчид хэт олширч их хэмжээний талбай хамарсан үед механик аргыг хэрэглэхэд ихээхэн зардал, цаг хугацаа, хүн хүч шаардагддаг. Иймээс малчид, иргэд мэрэгч амьтдыг хэт олшрохоос сэргийлж голомт бүхий нутгуудад байнгын хяналт тавьж илэрсэн даруйд нь цаг алдалгүй арга хэмжээ авч байх нь чухал. Ус цутгах, утах, цооноглох, хөөө ноохойг нь авах зэрэг энгийн механик аргууд нь үлийн цагаан оготнын амьдрах тохиромжтой орчныг нь алдагдуулж, идэш тэжээлийн нөөцийг нь устгадаг.

## УТАХ АРГА



Утах арга нь бага хэмжээний талбайд тархсан тохиолдолд түлхүү хэрэглэгдэх бөгөөд их хэмжээний тархалттай бэлчээрт бусад аргуудтай хослуулах нь зүйтэй. Үлийг хавар хөнөөлт

мэрэгчдийн тэсвэрт чанар нь буурсан, гаднын нөлөөнд эмзэг болсон үед утвал үр дүнтэй байдаг. Салхины дээд талаас утаж, утаа гарсан ойр нүхнүүдийг бөглөж, хамгийн хол нүхээр утаа гарах хүртэл үргэлжлүүлднэ. Утаж эхэлснээс хойш нүх, үлий утаагаар бүрэн дүүрсний дараа мэрэгчид нүхний амсарт ойртон ирээд эсвэл нүхнээс гарангуутаа муужирч унах үед уталтыг зогсооно. Дутуу утах, нүхийг муу бөглөх, ан цав ихтэй, сийрэг хөрстэй газар утаа амархан сарнидаг. Ийм нүхэнд утагдсан хөнөөлт мэрэгчид нүхэндээ муужрах боловч зарим нь сэргээд нүхнээс гарч болдог. Дулааны улиралд дусаал нүхийг өвлийн улиралд өвөлжих үлийг утах нь үр дүнтэй. Гар аргаар утахдаа аргал хомоол, чийгтэй өвс, модлог ургамал, сүрэл, тостой даавуу мэт шаталт удаан утаа их гаргадаг материалыг жижиг утагч зууханд шатааж утааг дэвэх, хөөрөгдөх аргаар нүх рүү оруулж утна. Харин уталтын дараа цогтой үнсийг заавал нүхэнд хийж булах хэрэгтэй. Утаж дуусаад бүх нүхийг сайтар бөглөж үлий дээр шороо овоолох, мод чулуу босгох зэргээр тэмдэг тавих нь ажлыг давхардуулан хийхгүй байх, үлий үлдсэн эсэхийг хянахад хэрэг болдог.



## УС ЦУТГАХ АРГА

Механик аргыг хэрэглэхэд мэрэгчдийн, нүх үлийний зохион байгуулалтын онцлогийг сайтар мэдэх нь чухал байдаг. Хавар, намрын шар ус, зуны бороо, үерийн ус, гадаргын усыг үлий нүх рүү суваг татаж оруулах, ус зөөж цутгах замаар гүйцэтгэнэ. Дулааны улиралд мэрэгчдийн дусаал нүхэнд ус цутган оготнын нүхнээс нь хөөн гаргадаг.

## ЦООНОГЛОХ АРГА

Цооноглох арга нь өвлийн улиралд ичээлсний дараа буюу дулааны улиралд хур бороо элбэгтэй үед үлийний хөөө, ноохойг авалгүйгээр нээж орхих үйлдэл юм. Үлийн доторх дулаан зохицуулалт алдагдах, үлий нүх хөөө цантаж хөлдөх, чийг нэмэгдсэнээр оготнын хөөө, ноохойн ялзралыг идэвхжүүлэх, хөлдөөх зэргээр амьдрах тохиромжтой орчныг өөрчлөх, идэш тэжээлийн нөөцгүй болгох зорилготой, байгаль орчинд халгүй, хүн, мал амьтанд аюулгүй, аль ч улиралд малчид, иргэд өдөр тутам хэрэглэх боломжтой үр дүнтэй арга юм.



## ХӨӨӨ, НООХОЙ АВАХ



Мэрэгчдийн өвөлжих үлийг цоолж хөөө, ноохойг гарган авах аргыг хэлнэ. Хөөө, ноохойг авсан нүхийг дахин ашиглахаас сэргийлж нүхэнд нь цас, ус, хийж норгох, чулуугаар чигжих, нүхний хонгил, салааг нураах, үлийний амсрыг нээж орхих хэрэгтэй. Гүйцэтгэх хугацааны хувьд хөөөг газар хөлдөхийн өмнөхөн, ургамал хагдарсны дараа эсвэл газар бага зэрэг хөлдсөн үед авахад тохиромжтой. Хөөөг эрт авахад дахин хураадаг. Намар 10 дугаар сарын дунд үеэс хойш авах нь үр дүнтэй. Хөөө, ноохойг авснаар дулаан хэвтэр, идэш тэжээлийн нөөцгүйгээс хүйтний улиралд амьд үлдэх боломжгүй болж, өвөлжих үлийд цугласан мэрэгчид бүлээрээ устгах боломжтой.

“Малын удмын сангийн үндэсний төв”-ийн захирал П.ГАНХУЯГ:

## ТӨР АНХ УДАА ӨӨРИЙН ГЭСЭН “ДОНОР” МАЛТАЙ БОЛЛОО



ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөс ОХУ-ын гурван мужаас шилмэл үүлдрийн 81 тооны малыг 540 гаруй сая төгрөгөөр авч ирж байгаа билээ. Энэ талаар “Малын удмын сангийн үндэсний төв”-ийн захирал П.Ганхуягаас тодрууллаа.

**–“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил”/нэмэлт санхүүжилт/ төслийн хүрээнд ОХУ-аас нийлүүлэгдэж буй малын онцлог, чанар, ашиг шимийн талаар танилцуулахгүй юу?**

Юуны өмнө төслийн хамт олонд талархаж буйгаа илэрхийлье. Монгол Улс социализмын үед Орос, Герман улсуудаас сайжруулагч малуудыг авч 400, 800 үнээтэй фермүүдийг байгуулж байсан ч генийн санд ашиглаж байгаагүй. Мөн зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш улсын төсвөөс ОХУ, БНХАУ, Франц, Польш зэрэг улсуудаас донор мал авдаг ч эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зарчихдаг байсан. Харин ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн шугамаар орж ирж буй мал бол үндэсний генийн санг бүрдүүлэх, материаллаг гол түүхий эдийг бэлтгэх зориулалтаар “Малын удмын сангийн үндэсний төв”-д ашиглагдах юм. Өөрөөр хэлбэл төр анх удаа өөрийн гэсэн донор малтай болж, түүнээсээ үр хөврөлөө гаргаж, ашиглаж цэвэр үүлдрийн малтай болох боломжтой болж байна гэсэн үг. Малын хувьд махны чиглэлийн Хар Ангус, Улаан Ангус, Герефорд, Халимаг үүлдрийн, мах-сүүний чиглэлийн Семминталь, хар тарлан үүлдрийн бух болон хар улаан Ангус, Герефорд, Халимаг, Хар



тарлан, Семминталь үүлдрийн үнээ нийлсэн нийт 56 толгой үхэр, нарийн ноост Алтай, нарийвтар ноост Цигай, мах-өөхний чиглэлийн Эдильбаев үүлдрийн 25 толгой хуц, нийт 81 толгой мал ирсэн байгаа. Төслийн 540 гаруй сая төгрөгийн санхүүжилтээр ОХУ-ын Москва хотын зүүн бүс, Алтай хязгаар, Эрхүү, Буриадын орчмоос Монгол оронд хамгийн тохиромжтой шилмэл үүлдрийн малнуудыг авчирсан. Эхний ээлжид бид төсөл хэрэгжиж буй 6 аймгийн 98 суманд хөнгөлөлттэй үнээр зохиомол хээлтүүлгийн ажлыг хийнэ. Дараа нь бүх сумдад шат дараатай хийх төлөвлөгөөтэй байгаа.

**–Та сая төр анх удаа өөрийн гэсэн донор малтай боллоо гэлээ. Дээрх сайн чанарын малыг авчирснаар өөр ямар давуу тал, үр дүн гарах вэ?**

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хамгийн давуу тал нь яг малчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлаж хөрөнгө оруулалт хийдэг учраас орон нутаг, малчдад нэн шаардлагатай, тулгамдсан асуудлыг шийдэж чаддаг. Жишээлбэл Орхон, Ерөө, Хангай чиглэлийн хонинуудын цус ойртсоноос үүдэн үүлдэр угсаа нь муудсан учир сайн чанарын хонины эрэлт хэрэгцээ их байсан. Сая ирсэн хуцнууд энэ эрэлт хэрэгцээг хангаж чадна. Өмнө нь Удмын сангийн үндэсний төв хувийн компаниудын оруулж ирсэн малаас үр үйлдвэрлэж авдаг учир чанар муутай байдаг байсан. Харин эдгээр малыг оруулж ирснээр сайн чанарын үр үйлдвэрлэж, удмын сангийн нөөцтэй болж байна. Түүнчлэн төр өөрийн гэсэн донор малтай болсон учир түүгээрээ үйлдвэрлэл явуулж, үйлчилгээ үзүүлэх нөхцөл нь хангагдаж байгаа юм. Мөн манай төвийн 15 ажилтан өмнө нь зөвхөн аж ахуйн нэгжүүдээс мал орж ирсэн үед л ажилладаг, бусад үед сул зогсолттой байсан бол одооноос бүгд байнгын ажлын байртай болж байна. Нөгөө талаараа бас нэг томоохон ач холбогдол нь Дархан чиглэлийн замаар зорчигчид зам зуураа Удмын сангийн үндэсний төвийн үзэсгэлэнгийн талбайд байх эдгээр малыг сонирхох боломж бүрдэж байгаа юм.

# ӨВӨРХАНГАЙД ҮЙЛДВЭРЛЭВ ТӨВ



“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл” болон орон нутгийн төсвийн 210 гаруй сая төгрөгийн санхүүжилтээр Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотод “Өвөрхангайд үйлдвэрлэв” төвийг 2020 оны 08 дугаар сард барьж, байгуулсан билээ.

“Өвөрхангайд үйлдвэрлэв” төвд одоогийн байдлаар 13 аж ахуйн нэгж, байгууллага, 19 хоршоо, 61 өрхийн үйлдвэрлэгчийн 16 нэр төрлийн 500 гаруй бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулж байна. Байгуулагдсан цагаасаа хойших жил гаруйн хугацаанд нийт 200 гаруй сая төгрөгийн борлуулалт хийжээ. Цаашид тус төвийн үйл ажиллагааг сайжруулах, үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх, онлайн дэлгүүр, цахим худалдаа, хүргэлтийн үйлчилгээг шат дараатай нэвтрүүлэх юм.



MADE IN UVURKHANGAI  
**Одод ааруул 500г**  
 Үйлдвэрлэгч: ӨВ-ОД цех  
 Өвөрхангай аймаг Арвайхээр сум  
[Uvurkhangaiishop.mn](http://Uvurkhangaiishop.mn)  
**77323333**

MADE IN UVURKHANGAI  
**Бөртэ чоно ГҮА МАРАЛ**  
 Үйлдвэрлэгч: Энхтөр  
 Өвөрхангай аймаг Хархорин сум  
[Uvurkhangaiishop.mn](http://Uvurkhangaiishop.mn)  
**77323333**

MADE IN UVURKHANGAI  
**Гоёоны дарс**  
 Үйлдвэрлэгч: Сүхдолгор  
 Өвөрхангай аймаг Арвайхээр сум  
[Uvurkhangaiishop.mn](http://Uvurkhangaiishop.mn)  
**77323333**

MADE IN UVURKHANGAI  
**Өндөг 10ш 4,500₮**  
 Үйлдвэрлэгч Төмөрбаатар





ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



ХӨДӨӨ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ  
ОЛОН УЛСЫН САН

# ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧИД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

ЗЭЭЛ

ЗЭЭЛИЙН ХҮҮ (жилийн):

**12%**



ЗЭЭЛИЙН ХУГАЦАА:

**60** ХҮРТЭЛ  
САР

ЗЭЭЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭ:

**75** ХҮРТЭЛ  
САЯ ТӨГРӨГ

НИЙТ ЗЭЭЛИЙН ДҮНГИЙН **50 ХҮРТЭЛ** ХУВЬД  
БАТЛАН ДААЛТАНД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ.



ИРГЭДЭД ЗОРИУЛСАН

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

ЗЭЭЛ

ЗЭЭЛИЙН ХҮҮ (жилийн):

**10.8%**

ЗЭЭЛИЙН ХУГАЦАА:

**36** ХҮРТЭЛ  
САР

ЗЭЭЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭ:

**20** ХҮРТЭЛ  
САЯ ТӨГРӨГ

ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ ТӨСӨЛ

НИЙТ ЗЭЭЛИЙН ДҮНГИЙН **80 ХҮРТЭЛ** ХУВЬД БАТЛАН ДААЛТАНД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ.

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН

## ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН

ЗЭЭЛ

ЗЭЭЛИЙН ХҮҮ (жилийн):

**10.8%**

ЗЭЭЛИЙН ХУГАЦАА:

**24** ХҮРТЭЛ  
САР

ЗЭЭЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭ:

**10** ХҮРТЭЛ  
САЯ ТӨГРӨГ

ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ ТӨСӨЛ